


МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ  
ТЭМЦЭХ, ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН ГАРЫН АВЛАГА







**БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН  
МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ  
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ,  
ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ГАРЫН АВЛАГА**

2021 он



## ӨМНӨХ ҮГ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа нь дэлхий нийтэд тулгамдаад томоохон асуудлуудын нэг бөгөөд үүнтэй тэмцэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ чиглэлээр эрх бүхий байгууллага буюу ФАТФ-аас улс орнуудын МУТСТ тогтолцоонд байнгын хяналт тавьж, үнэлгээ өгч, алдаа дутагдлыг залруулах чиглэлд даалгавар өгдөг. ФАТФ болон АНДМУТБ зэрэг ФАТФ-тай төстэй бүс нутгийн байгууллагуудаас улс орнуудын МУТСТ үйл ажиллагааг хуваарьт байдлаар шалгадаг. Манай улсын хувьд ФАТФ-ын стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй орнуудын жагсаалтаас 2020 онд гарч, үүрэг даалгаврыг богино хугацаанд шуурхай биелүүлж, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх чиглэлд амжилттай ажилласан. Энэхүү амжилт, дэвшлийг тасралтгүй хангах, ФАТФ-ын стандартыг үргэлжлүүлэн биелүүлж, хууль бус үйл ажиллагааг хамтын хүчээр таслан зогсооход нэн тэргүүний чиглэл хэвээр үргэлжлүүлэн анхаарч ажиллах шаардлага үүсээд байна.

Мэдээлэх үүрэгтэй этгээд буюу санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчдад үйлчилгээ үзүүлэхэд сэжигтэй үйлдэл, их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээг СМА-нд мэдээлэх, харилцагчийг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний жагсаалттай тулгаж, тайлан, мэдээг хүргүүлэх зэргээр МУТСТ-д багагүй үүргийг гүйцэтгэдэг. Банкнаас бусад санхүүгийн байгууллагууд болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид зэрэг санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь МУТСТ, ҮОХЗДТ чиглэлээр хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд онцгой үүрэгтэй. Иймээс мэдээлэх үүрэгтэй этгээдүүд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хууль, холбогдох журам, зааврыг мөрдөж, МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг байнга авах ёстой.

Иймд, Санхүүгийн зохицуулах хорооноос өөрийн 6 зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хууль, холбогдох журам, зааврыг мөрдөхөд туслалцаа үзүүлэх зорилгоор ээлжит гарын авлагыг салбар тус бүрийн онцлог, жишээтэй боловсруулаад байна. Энэхүү гарын авлагад МУТСТ, ҮОХЗД-тэй үйл ажиллагааны талаарх ойлголт, хамтын ажиллагааны хүрээний байгууллага, тэдгээрийн үүрэг, МУТС эрсдэлийг үнэлэх, харилцагчийг таньж мэдэх, гүйлгээний мэдээллийг СМА-нд хүргүүлэх, санхүүгийн зорилтот хориг арга

хэмжээ зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдийн хэрэгжүүлэх үүргүүдийн талаар жишээ, кейсүүдээр тайлбарлаж орууллаа.

Мэдээлэх үүрэгтэй этгээд та бүхэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай хуулиуд, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангахад энэхүү гарын авлагыг ашиглаж МУТСТ, ҮОХЗДТ үр дүнтэй тогтолцоог цогцлоож ажиллана гэж бид найдаж байна.

## АГУУЛГА

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

#### **БҮЛЭГ 1. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

- 1.1. Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн ойлголт, хэлбэр, үе шатууд .....9
- 1.2. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндсэн ойлголт, үе шатууд....11
- 1.3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх ..... 13
- 1.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийн хор хөнөөл .....14
- 1.5. Хууль эрх зүйн орчин..... 15

#### **БҮЛЭГ 2. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГУУЛАХ ЭТГЭЭД**

- 2.1. Олон улс дахь эрх бүхий байгууллагууд /ФАТФ, АНДМУТБ, НҮБ, бусад/ ..... 17
- 2.2. Үндэсний зөвлөл ..... 18
- 2.3. Терроризмтой тэмцэх зөвлөл ..... 19
- 2.4. Хамтын ажиллагааны зөвлөл, гишүүн байгууллагууд ..... 19
- 2.5. Санхүүгийн мэдээллийн алба ..... 19
- 2.6. Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллагууд .....20
- 2.7. Мэдээлэх үүрэгтэй этгээд .....20

#### **БҮЛЭГ 3. МЭДЭЭЛЭХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

- 3.1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг .....22
- 3.2. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих .....23
- 3.3. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо 25
- 3.4. Жишээ, тохиолдол .....26

## **БҮЛЭГ 4. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

4.1. Эрсдэлийн тухай ойлголт, яагаад үнэлэх хэрэгтэй вэ? .....	29
4.2. Үндэсний эрсдэлийн үнэлгээ .....	29
4.3. Салбарын эрсдэлийн үнэлгээ .....	30
4.4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн үнэлгээ .....	31
4.5. Эрсдэлийн удирдлага, эрсдэлд суурилсан аргачлал .....	34
4.6. Жишээ, тохиолдол .....	38

## **БҮЛЭГ 5. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, ГҮЙЛГЭЭГ ТАЙЛАГНАХ**

5.1. Харилцагчийг таньж мэдэх тухай, хялбаршуулсан болон нарийвчилсан үйл ажиллагаа .....	40
5.2. Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх .....	44
5.3. Гүйлгээнд тавих хяналт, гүйлгээг мэдээлэх /БМТ, ГТТ, СГТ/ .....	45
5.4. Сэжигтэй үйлдэл, сэжигтэй гүйлгээ .....	46
5.5. Эцсийн өмчлөгч тогтоох .....	50
5.6. Улс төрд нөлөө бүхий этгээд .....	51
5.7 Жишээ, типологи .....	53

## **БҮЛЭГ 6. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

6.1. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдол .....	54
6.2. Сургалт, мэдээлэл .....	54
6.3. Баримт материалын аюулгүй байдал .....	55
6.4. Нууцлалын аюулгүй байдал .....	56
6.5. Анхааруулга .....	56

## **БҮЛЭГ 7. САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ**

7.1. Монгол Улс ба санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ .....	57
--	----

## **БҮЛЭГ 8. ШААРДЛАГАТАЙ БУСАД**

8.1. Монгол Улс ба Саарал жагсаалт .....	61
8.2. Мэдээ мэдээллийг олж авч болох эх сурвалжууд .....	65

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>ФАТФ</b>	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
<b>АНДМУТБ</b>	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
<b>СЗХ</b>	Санхүүгийн зохицуулах хороо
<b>СМА</b>	Санхүүгийн мэдээллийн алба
<b>МУТС</b>	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
<b>МУТСТ</b>	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
<b>ҮОХЗДТ</b>	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх
<b>МҮЭ</b>	Мэдээлэх үүрэгтэй этгээд
<b>ББСБ</b>	Банк бус санхүүгийн байгууллага
<b>БМГТ</b>	Бэлэг мөнгөний гүйлгээний тайлан
<b>ГТТГТ</b>	Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан
<b>СГТ</b>	Сэжигтэй гүйлгээний тайлан
<b>ҮЭҮ</b>	Үндэсний эрсдэлийн үнэлгээ

# 1

## БҮЛЭГ

# МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

### 1.1 Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн ойлголт, хэлбэр, үе шатууд

“МӨНГӨ УГААХ” – Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

**Өөрөөр хэлбэл:** Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

Мөнгө угаах нь ихэвчлэн дараах үндсэн зорилготой. Үүнд:

- Хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын эх үүсвэрийг өөрчлөх, шилжүүлэх;
- Хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга болон эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх, нуун далдлах;
- Хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого олж авах, эзэмших, ашиглах, үр шимийг нь хүртэх;
- Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд хамтран оролцох, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах, хамжих, туслах болон зөвлөгөө өгөх гэх мэт.

**Хууль бус, гэмт хэрэг гэдэгт:** Хууль бус галт зэвсгийн наймаа, хүний, эд эрхтний наймаа, хар тамхины худалдаа, бусдын биеийг үнэлүүлэх, **мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдвэрлэх, авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх**, байгаль орчны эсрэг, гэмт хэрэг, **хулгай, дээрэм, цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр**, далд веб дэх **хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютаар олсон орлого** гэх мэт мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүд орно.

Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбар гэлтгүй хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарыг оролцуулж ашиглах, гүйлгээ хийх нь түгээмэл байдаг. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгө, орлогыг илрүүлэхэд олон салбарыг хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардлагатай болдог. Мөнгө угаагчид гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо олон улсын болон дотоодын зах зээл дээр ашиглагдаж байгаа төлбөр тооцооны хэрэгслүүд, өндөр өртөгтэй хөрвөх чадвартай үнэт металл, үнэт эдлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи зэргийг ашиглан хэлбэр, төрхийг нь хувиргахыг оролддог. МУТС үйл ажиллагаа нь байршуулах, нуун далдлах, буцаан төвлөрүүлэх гэсэн гурван үе шаттай үйлдэгддэг.



## Байршуулах

*Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны болгож санхүүгийн системд байршуулах буюу мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл хууль хяналтын байгууллагын анхаарлыг таталгүйгээр санхүүгийн системд нэвтрүүлж, хууль бусаар олсон мөнгөний анхны эх үүсвэрээс “салах” явдал юм.*

## Нуун далдлах

*Хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, төөрөгдүүлэх зорилгоор эргэлзээ төрүүлж, олон төрлийн ээдрээтэй гүйлгээ хийж санхүүгийн системийн эргэн тойронд эргэлдүүлэх үйл явц юм. Энэ үе шат нь хамгийн нарийн төвөгтэй ба мөнгөний жинхэнэ үүсвэрийг олж илрүүлэхэд хүндрэлтэй болгож “бохир” мөнгөний зүсийг хувиргаснаар жинхэнэ эх үүсвэрээс хөрөнгийг аль болох холдуулж өгөх зорилготой.*

## Буцаан төвлөрүүлэх

*Мөнгө угаах гэмт хэргийн эцсийн зорилго нь нийлүүлэлт буюу буцаан төвлөрүүлэлт юм. Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон хөрөнгийг санхүүгийн системд нэвтрүүлээд нуун далдлах үе шатны дараа буцаан төвлөрүүлэх үе шат руу шилжүүлэх ба энэ үед нэмэлт гүйлгээнүүдийг хийх замаар хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог. Мөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого мэт харагдуулахыг зорино.*

## 1.2. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндсэн ойлголт, үе шатууд

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд **“ТЕРРОРИЗМ”** гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа гэж заасан..

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд **“ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ”** гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ гэж тодорхойлсон.

Тэгэхээр Мөнгө угаах үйл ажиллагааны гол сэдэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо эрэлхийлэх байхад, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн сэдэл нь үзэл сурталтай шууд холбоотой ба энэ нь шашин шүтлэг, улс төр, өш хонзон, бэлэг тэмдгийн аль нэг нь байдаг. Террорист үйл ажиллагаа нь хүний амь насыг санаатай бүрэлгэх, үй олноор хөнөөх, хүн барьцаалах,

гэмтээх, түүх, соёлын үнэт өвийг санаатай хорлон сүйтгэх замаар төр засаг болоод олон улсын байгууллагыг аливаа нэг үйлдэл хийлгэхгүй байх тактик юм.

Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбож үздэг. Гэвч агуулгын хувьд энэ хоёр төрлийн гэмт хэрэг нь тусдаа үйлдэгддэг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор ч бас санхүүжиж болдог. Тухайлбал:

### **Хууль бус санхүүжилтийн эх үүсвэр:**

Айлган сүрдүүлэх замаар мөнгө дээрэмдэх, хүн барьцаалж мөнгө нэхэх, хүний наймаа, хар тамхины худалдаа зэрэг хууль бус үйлдлүүд нь санхүүжилтийн томоохон эх үүсвэр болдог. Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэж дамжуулах, залилан, хулгай дээрэм хийх, хувийн мэдээллийг хулгайлж мөнгө нэхэх, хууль бусаар үнэт металл, үнэт чулуу олборлох, хандив, тусламжийн хөрөнгийг зүй бусаар ашиглах зэрэг үйл ажиллагааг мөн дурдаж болно.

### **Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэр:**

Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэрийг гадны улс орнуудын төр засгаас өгсөн хандив, тусламж, бизнес болон хувиараа хөдөлмөр эрхэлж олсон хууль ёсны орлого зэрэг бүрдүүлнэ. Харамсалтай нь хандивлагчид өөрийн хандивласан хөрөнгийг терроризмыг дэмжсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн талаар мэдэхгүй өнгөрөх тохиолдлууд гардаг. Хууль ёсны байгууллагууд мөн л террорист байгууллагуудыг санхүүжүүлсэн тохиолдлууд гардаг.

Терроризмыг санхүүжүүлэх нь мөнгө угаах гэмт хэрэгтэй төстэй байдлаар үйлдэгддэг бөгөөд дараах үе шаттай.

### Хөрөнгө босгох үе шат

- *Хууль бус болон хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого*
- *Хандив, тусламж, ашгийн бус байгууллагууд*
- *Нийтийн сүлжээ ашиглах*

### Хөрөнгийг шилжүүлэх, хөдөлгөх үе шат

- *Хууль бусаар хилээр нэвтрүүлэх*
- *Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах, төлбөр тооцооны хэрэгслээр дамжуулах, криптовалютаар шилжүүлэх*
- *Хавала, хунди зэрэг хууль бус сүлжээ ашиглах*

### Хөрөнгийг хэрэглэх үе шат

- *Пропаганда*
- *Террорист үйл ажиллагааг зохион байгуулах, зэвсэг худалдан авах*
- *Цалин хөлс олгох гэх мэт*

## 1.3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх

### **“ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ”**

гэж Монгол Улсын Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг” хэлнэ гэж заажээ.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх нь хүний амь нас, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, цаашлаад олон улсын энх тайван, аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулж байна. Террорист байгууллага, бүлэглэл болон бусад этгээдийн зүгээс түүнийг олж авахыг эрмэлзэж байгаа нь эрсдэл дагуулж байна. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэхээр зэхэж буй этгээдүүдтэй холбоотой аливаа санхүүгийн урсгалыг таслан зогсоох нь чухал ач холбогдолтой юм.

Олон улсад “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” ойлголтын талаар нэгдсэн тодорхойлолтод хараахан хүрээгүй байгаа бөгөөд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 тогтоолд үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын үүрэг, хариуцлагыг тогтоож,

улс орнуудыг үр дүнтэй тэмцэх, эрүүгийн, иргэний, захиргааны эрх зүйн чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалж байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Хоригийн хорооноос тогтоол гаргаж ИБНИУ болон БНАСАУ-ын эсрэг үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авч байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн эдгээр тогтоолууд нь үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн санхүүгийн өргөн хүрээний арга хэмжээг агуулдаг.

НҮБ-аас тавьж буй аливаа хориг арга хэмжээ нь санхүүгийн зорилтод хориг арга хэмжээнээс гадна үйл ажиллагаанд суурилсан санхүүгийн хориг, эдийн засаг, тодорхой нэг салбарын хориг арга хэмжээ болон холбогдох санхүүгийн хориг, сонор сэрэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг багтаана. Түүнчлэн лавлах жагсаалт, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолуудын хориг арга хэмжээний үүргийн дэлгэрэнгүй тайлбарыг тус тус багтаасан байна.

#### **1.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийн хор хөнөөл**

Мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь биднээс хол хөндий олон улс, хөгжингүй орнуудад, мөргөлдөөнтэй бүс нутагт л үйлдэгддэг гэмт хэрэг огт биш бөгөөд бидний эргэн тойронд ч үйлдэгддэг байна. Тухайлбал, авилга хээл хахууль, татвараас зайлсхийх, орлогоо нуун дарагдуулах, хүн хулгайлах, бусдын биеийг үнэлүүлэх, хулгай дээрэм, цахим гэмт хэрэг цаашлаад байгаль орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болдог.

Мөн мөнгө угаах гэмт хэрэг нь нүдэнд үзэгдэхгүй боловч далд эдийн засгийг бий болгож улс орны нийгэм, эдийн засагт том хохирол учруулдаг ба бидний өдөр тутмын амьдралд нөлөөлдөг байна.

МУТС гэмт хэрэг нь эдийн засаг, нийгэмд өндөр хор уршигтай байдаг. Хамгийн энгийн жишээ гэвэл хэрэв хууль бус их хэмжээний хөрөнгө манай улсын санхүүгийн системээр угаагдаж байвал нэн түрүүнд санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учруулдаг. Хууль бус хөрөнгө нь дотоодынх бол авилга хээл хахуулийг ихэсгэх, шудрага өрсөлдөөнийг үгүй хийнэ. Мөн МУТС гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байдал нь олон улсын тавцанд улс орны нэр хүндийг унагахаас гадна тухайн улсын санхүүгийн систем, цаашлаад улс үндэстэнд итгэх итгэлийг үгүй хийх ба олон улсын эрх бүхий байгууллагуудын эрчимтэй хяналтад орж эхэлдэг. Үүний үр дүнд олон улсын санхүүгийн системд эрсдэлтэй гэж үзэгдэн аливаа хаалт, шахалтад орж эдийн засаг тэлэх боломж хумигдах, тухайн улсын иргэдийн өдөр тутмын амьдралд нөлөөлдөг байна.

Тухайлбал Монгол Улс ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д ороход үүнээс шалтгаалж Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулж байсан.

### 1.5. Хууль эрх зүйн орчин

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь зөвхөн дээрх хуулиас гадна Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийг мөн адил дагаж мөрдөх үүрэгтэй төдийгүй эдгээр хууль тогтоомжийг дагаж гарсан журам, зааврыг мөрдөх шаардлагатай. Эдгээр хууль тогтоомж нь мэдээлэх үүрэгтэй этгээдийг МУТС гэмт хэргээс сэргийлэхэд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэх, суурь болдог байна.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасны дагуу Хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж байгаа этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно гэж заасан бөгөөд мэдээлэх үүрэгтэй этгээд нь “Хүн, хуулийн этгээд аливаа үйлчилгээ үзүүлэхдээ хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцааж тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлнэ.” гэж заасны дагуу мэдээлэх үүрэгтэй.

ББСБ-ууд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хуулиудаас гадна эдгээр хуультай нийцүүлэх баталсан журам зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай. Эдгээрийг дурдвал:

### Хууль

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Бусад

## Журам

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;
- Үй олноор хөнөөр зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам;
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам;
- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам;
- Бусад

Дээрх хууль тогтоомжийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь тодорхой эрхийг эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хуулийн хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.10, 11.29 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн 166<sup>1</sup>, 178<sup>2</sup> дугаар зүйл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох албадлагын арга хэмжээ, мөнгөн торгууль, цаашлаад олсон хөрөнгийг хураах, ял шийтгэл оногдуулах хүртэл арга хэмжээг авдаг болохыг анхаарах нь зүйтэй. .

# 2

## БҮЛЭГ

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГУУЛАХ ЭТГЭЭД

#### 2.1. Олон улс дахь эрх бүхий байгууллагууд

##### ***Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/***

ФАТФ нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм.

ФАТФ нь Их долоогийн уулзалтаар 1989 онд байгуулагдсан, 35 өндөр хөгжилтэй улс, 2 бүс нутгийн холбоо гишүүдээс бүрддэг бөгөөд бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

ФАТФ-аас гишүүн улс орнуудын МУТСТ тогтолцоог тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж хянадаг. ФАТФ-ын Харилцан үнэлгээ нь 2012 онд баталсан 40 Зөвлөмжийн дагуу Техникийн хэрэгжилт (хууль, эрх зүй болон үйл ажиллагааны тогтолцоо) болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлдэг.



## **Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/**

1997 онд байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн байгууллага (The Asia/Pacific Group on Money Laundering буюу АНДМУТБ) нь ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд МУТСТ үйл ажиллагааг зохицуулах байгууллага бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр нь элссэн билээ.

## **Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл /НҮБАЗ/**

НҮБАЗ-ийн тогтоолд хориг арга хэмжээ авах тухай тогтоол хамрагддаг. Хориг арга хэмжээ гэдэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалж хамгаалах зорилгоор Аюулгүйн зөвлөлөөс баталсан арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээг авахдаа зэвсэгт хүчнийг оролцуулдаггүй. НҮБ-ын дүрмийн VII бүлгийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс тодорхой улс гүрэн, хүн, хуулийн этгээдэд эдийн засгийн болон бусад хориг арга хэмжээ ногдуулах зэрэг арга хэмжээ авдаг. Эдгээр хориг арга хэмжээнд хилийн хориг тогтоох, бараа, бүтээгдэхүүний хязгаарлалт болон зэвсгийн хориг зэрэг ордог. Санхүүгийн зорилтот арга хэмжээ гэдэг нь жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн хөрөнгө царцаах зэрэг санхүүгийн хязгаарлалт тавьдаг хориг арга хэмжээний өөр нэг төрөл юм. НҮБАЗ-ийн тогтоолыг НҮБ-ын гишүүн улс орон бүр биелүүлэх үүрэгтэй.



### **ШИГТГЭЭ:**

Монгол Улсыг 2019 оны 10 дугаар сард ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад орсонтой холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Европын Холбооны **өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулаад байсан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр уг жагсаалтаас хассан билээ.**

## **2.2. Үндэсний зөвлөл**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжаар Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг анх байгуулсан.

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр баталсан ба тус өөрчлөлтөөр Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа болон бүрэлдэхүүний зохицуулалтыг тусган Монгол Улсын Ерөнхий сайдын

2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 144 дугаар захирамжаар Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж Хууль зүй, дотоод хэргийн сайд даргалах болсон.

### **2.3. Терроризмтой тэмцэх зөвлөл /ТТЗ/**

ТТЗ нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д зааснаар “хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах” эрх хэмжээтэй байхаар хуульчилсан. Иймд ТТЗ нь санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнийг хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байна.

### **2.4. Хамтын ажиллагааны зөвлөл /ХАЗ/, гишүүн байгууллагууд**

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлд Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллахаар заасан байдаг.

Мөн тус байгууллагын үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн дугаар А-116 тоот тушаалаар Хамтын ажиллагааны зөвлөл нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, Санхүүгийн мэдээллийн албаны стратеги, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зардлыг батлахад Монгол банкны Ерөнхийлөгчид санал өгөх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх Монгол Улсын эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар бодлого, зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл болно.

Хамтын ажиллагааны зөвлөлийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар 1 жилийн хугацаатай даргалахаар заасан байдаг.

### **2.5. Санхүүгийн мэдээллийн алба /СМА/**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, мэдээлэх үүрэгтэй этгээдээс энэ

хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний тухай мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна гэж заасан байдаг.

## 2.6. Санхүүгийн зохицуулах хороо болон бүсэд

Санхүүгийн зохицуулах хороо өөрийн зохицуулалттай салбарууд болох үнэт цаас, даатгалын салбарын оролцогчид, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод, үл хөдлөх эд хөрөнгө зүүчлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хүлээж ажилладаг. Энэ ажлын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбарын оролцогчдод сургалт, семинар зохион байгуулах, мэдээ мэдээлэл түгээх, гарын авлага, брошур боловсруулж түгээх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. МУТСТ чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг нийт зохицуулалттай салбаруудад нэвтрүүлэх ажлын хүрээнд МУТС, ҮОХЗД эрсдэлийг салбараар үнэлэхээс гадна байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлж, эрсдэлийн төвшинд суурилсан зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой илэрсэн дутагдалд мэдэгдэл, хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлага хүргүүлдэг бол илэрсэн зөрчилд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулиудад заасны дагуу захиргааны арга хэмжээ авч ажилладаг.

Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын прокурорын ерөнхий газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Мэргэжлийн холбоодууд гэх мэт олон байгууллага хувь нэмрээ оруулан, хүчин чармайлт гарган ажилладаг.

## 2.7. Мэдээлэх үүрэгтэй этгээд /МҮЭ/

Мөнгө угаах гэмт хэрэгт хэн ч өртөх боломжтой байдаг. Иргэд энэ төрлийн гэмт хэргийн үйлдэлд мэдлэг мэдээлэл дутмагаас болж мэдэлгүй оролцох, мэдэх боломжтой байсан боловч өнгөрүүлэх зэрэг тохиолдол гарч болно. Мөн мөнгө угаахаар зорьж буй этгээд нь “бохир мөнгө”-ийг хамгийн

түрүүнд санхүүгийн болон санхүүгийн бус салбарын байгууллага, этгээдээр дамжуулан эх үүсвэрийг далдлахыг зорьдог. Энэ эрсдэлээс сэргийлэх, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхээр эдгээр байгууллага этгээдийг “Мэдээлэх үүрэгтэй этгээд” гэж үзэн хуулийн дагуу тодорхой эрх, үүргийг олгосон байдаг.

МҮЭ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар тодорхойлогдсон МУТСТ, ҮОХЗДТ чиглэлээр үүрэг хүлээсэн этгээдийг хэлэх ба Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар доор дурдсан этгээдүүдийн МҮЭ гэж үздэг байна. Үүнд:

1. Банк;
2. Банк бус санхүүгийн байгууллага;
3. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
4. Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
5. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
6. Хадгаламж, зээлийн хоршоо;
7. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
8. Энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
9. Нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:
  - i. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
  - ii. харилцагчийн хөрөнгийг удирдах;
  - iii. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
  - iv. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
  - v. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

# 3

## БҮЛЭГ

### МЭДЭЭЛЭХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

#### 3.1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар “Мэдээлэл үүрэгтэй этгээд” гэж хэн болохыг хуульчилсан байдаг ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тодорхой эрх үүргийг олгосон.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Банк бус санхүүгийн байнууллага” гэж тусгасан байдаг нь Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ нь энэхүү хуулиараа МҮЭ гэж үзэгдэх бөгөөд зөвхөн энэхүү хууль биш Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид хамааралтай юм.

#### НЭМЖ ХЭЛЭХЭД:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д ББСБ-с гадна бусад этгээдийг заасан төдийгүй санхүүгийн болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид багтсан байдаг байна. Тухайлбал, банк, ББСБ, ХЗХ, үнэт цаас, даатгалын мэргэжлийн оролцогчдоос гадна үл хөдлөн эд хөрөнгө зүүчлагч, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, хуульч, нягтлан бодогчид, нотариатчийг мөн адил МҮЭ гэж үздэг байна.

Энэ нь ФАТФ-ын зөвлөмж, шаардлагын дагуу улс орнууд өөрийн МУТСТ тогтолцоондоо адил тусгасан байх ба улс орнууд дээрх этгээдийг МҮЭ гэж үзнэ.

МУТСТ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд дараах үүрэгтэй байна. Үүнд:

- Гүйлгээндээ хяналт тавих
- Тодорхой гүйлгээний талаар СМА-нд тогтоосон хугацаанд мэдээлэх
- Эцсийн өмчлөгч тогтоох
- Харилцагчаа таньж мэдэх
- Гүйлгээний хяналт, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дагуу тусгай хяналт тавих

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх
- Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах
- Мэдээллийн нууцлалыг хадгалах
- МУТСТ дотоод хяналтыг хэрэгжүүлэх

**АНХААРУУЛАХАД:**

*ББСБ нь мэдээлэх үүргийн хүрээнд харилцагч холбоотой мэдээлэл, гүйлгээний мэдээлэл зэргийг СМА, эрх бүхий байгууллагад хүргүүлэх буюу МУТСТ үүргээ биелүүлсэн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар аливаа нууцыг задруулсан гэж үзэхгүй бөгөөд мэдээлэл өгсөнтэй холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.*

*Харин ББСБ нь хүргүүлж буй мэдээллийн нууцлалыг чанд хадгалах бөгөөд үүнийг хуульчлан заажээ.*

### **3.2. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн МУТСТ үйл ажиллагаанд тавих хяналт**

ББСБ нь тусгай зөвшөөрөл авснаас эхлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар МҮЭ болох бөгөөд мөн хуулийн 14 дүгээр зүйлд заасан дотоод хяналтын дагуу МУТСТ чиглэсэн “Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг баталж, эрх бүхий зохицуулагч байгууллагадаа бүртгүүлэх шаардлагатай.

МУТСТ дотоод хяналтын хөтөлбөр гэдэг нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн МУТСТ чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх дотоод журам, дүрмийн цогц хөтөлбөр юм. Дотоод хяналтын хөтөлбөр нь хууль тогтоомжийг мөрдөхөөс гадна МУТС эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж юм.



ББСБ нь “Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг батлахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.” гэж заасны дагуу батлах бөгөөд тухайн ББСБ-ын цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалтад нийцсэн байх ба МУТСТ чиглэлээр эрсдэлийн бууруулахад чиглэх бөгөөд агуулгын хүрээнд ямар байх талаар мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д тус бүрчлэн заасан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу ББСБ нь дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг шинээр батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах үедээ СЗХ-нд заавал бүртгүүлэх шаардлагатай бөгөөд СЗХ нь хууль тогтоомжид нийцэж буй байдалд дүгнэлт өгч, бүртгэдэг байна.

Энэхүү хөтөлбөр нь тухайн ББСБ-ын МУТСТ чиглэлээрх үйл ажиллагаанд байнга хэрэглэгдэх зааварчилгаа, хууль тогтоомжийг мөрдөх гол баримт бичиг болох бөгөөд ББСБ нь өөрийн газар зүйн байршил, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчдийн тоо, салбар төлөөлөгчтэй эсэх зэргээс хамаарч тохирсон байдлаар боловсруулан батлах шаардлагатай.

### ***МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт ямар асуудлыг тусгах шаардлагатай вэ?***

1. Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;
2. Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;
3. Шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;
4. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны журам;
5. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;
6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;
7. Тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;

8. Корреспондент банкны харилцаа тогтоох журам;
9. Мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам;
10. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, СМА болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;
11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;
12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;
13. Хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага.

Тодруулга: Дээрх анхаарах бүх асуудлыг МҮЭ-дэд ерөнхий байдлаар хэрэгжүүлэхээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан байдаг. Иймд ББСБ нь өөрийн тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс хамаарч тохирсон байдлаар боловсруулах бөгөөд салбарын болон ББСБ-ын онцлогоос шалтгаалж өөр өөр байж болох юм.

ББСБ нь МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг батлахын зэрэгцээ энэ үйл ажиллагаанд хяналт тавих ажилтанг заавал томилох бөгөөд тухайн ажилтан нь гүйцэтгэх албаны ажилтан эсхүл ББСБ-ын ажилтан нь хавсарч эрхлэх боломжтой. Гагцхүү тухайн томилсон албан тушаалтан нь идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжтой, МУТСТ чиглэлээр мэдлэг, мэдээлэл өндөртэй, өндөр ёс зүйтэй байх шаардлага. Мөн тус албан тушаалтанг нь гүйцэтгэх захирлын тушаал, ТУЗ-ийн шийдвэрээр баталж болдог.

### **3.3. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо**

МУТСТ чиглэлээр ББСБ-ын дотоодын үйл ажиллагаанд харилцан уялдаа холбоотой ажиллах нь түн чухал. Энэ нь зөвхөн нэг ББСБ-аар зогсохгүй тухайн салбарын МУТСТ үйл ажиллагааг үр дүнд хүргэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой байдаг байна. ББСБ-ын хувьд хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх албын мэдээллийн солилцоо, ажил үүргийн тодорхой байдал чухал юм.

*ББСБ нь МУТСТ чиглэлээр явуулж буй дотоод үйл ажиллагааны уялдаа*

*холбоог хэрхэн сайжруулах вэ?*

**Алхам 1:** ББСБ-ын хувьцаа эзэмшигчид, ТУЗ, ажилтнууд МУТСТ чиглэлээр мэдээлэх үүрэгтэй холбоотой мэдлэг мэдээлэлтэй байх

**Алхам 2:** ББСБ нь МУТС эрсдэлийн үнэлгээг үнэлсний үндсэн дээр дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр боловсруулах, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийх

**Алхам 3:** Баталсан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт хуулийн хэрэгжилт хангуулах ажилтны ажил үүргийн хуваарийг тусгасан эсэхийг нягтлан, хэрхэн хяналт тавих талаар гүйцэд тусгах

**Алхам 4:** ТУЗ-ийн хурлаар МУТСТ чиглэлээр хийсэн асуудлаа хэлэлцэх, холбогдох сургалт мэдээлэл олгох гэх мэт үйл ажиллагааг тогтмол явуулах.

Түүнчлэн хуулийн хэрэгжилт хангуулахаар томилогдсон ажилтан нь тухай бүр мэдээ, тайланг СЗХ-нд хүргүүлэх ба МУТСТ чиглэлээр хийсэн ажлын тайланг дотооддоо танилцуулдаг, мөн МУТСТ холбоотой үйл ажиллагааны зохих шаардлагыг тавьдаг байх хэрэгтэй юм.



### 3.4. Жишээ, тохиолдол

**Жишээ 1:** Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр батлаагүй нь тогтоогдсон нь

СЗХ нь эрх үүргийн хүрээнд ББСБ-уудад зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад тодорхой хугацаанд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ нь дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр баталсан хэмээн мэдээлэл өгчээ. Энэ мэдээлэл дээр үндэслэн тухайн ББСБ-аас холбогдох баримт материалыг ирүүлэхийг шаардсан байна. Тогтоосон хугацаанд тухайн ББСБ-аас дотоод хяналтын хөтөлбөрийг ирүүлээгүй бөгөөд хугацаа хэтэрсний

дараагаар ирүүлсэн “Дотоод хяналтын хөтөлбөр” гэх нэртэй баримт бичиг нь ББСБ-аас батлаагүй, хуульд нийцэхгүй байгаа нь тогтоогдсон.

### **Зөрчигдсэн хууль тогтоомжийн заалт нь:**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.”, 14.5-д “Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.” гэж тус тус заасан ба уг заалтыг зөрчсөн нь Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 19.1-д мэдээлэх үүрэгтэй этгээд нь дотоод хяналтын хөтөлбөр баталж бүртгүүлээгүй нь хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасны дагуу тухайн ББСБ-ыг 5 сая төгрөгөөр торгох үндэслэл бүрдсэн байна.

Мөн СЗХ-нд хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн боловч хугацаандаа биелэлт ирүүлээгүй, худал мэдээлэл өгсөн тул Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан арга хэмжээг давхар авах нөхцөл бүрдэж байна.

### **Жишээ 2:** Газар дээрх хяналт шалгалтаар зөрчил илэрсэн нь

СЗХ-нд нэр бүхий ББСБ-уудад МУТСТ чиглэлээр эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтыг явуулахаар удирдамж батлуулан, ажлын хэсэг байгуулагдан тодорхой хугацаанд газар дээрх хяналт шалгалтыг явуулжээ. Газар дээрх хяналт шалгалтыг удирдамжийн дагуу тухайн ББСБ-ын байранд ажиллан, баримт материалд тулгуурлан шалгах явцад нэр бүхий 2 ББСБ нь МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр бүрэн гүйцэд боловсруулан батлаагүй, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцээгүй байх зөрчил илэрсэн байна. Гарсан зөрчил нь ялгаатай байсан хэдий ч тухайн ББСБ-ын гэх МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хангалттай гэж үзэх боломжгүй юм.

**ББСБ №1:** Нэр бүхий ББСБ нь газар дээрх хяналт шалгалтын үеэр МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр баталсан хэмээн эх хувийн гаргаж өгсөн. Ажлын хэсгийн зүгээс тухайн хөтөлбөртэй танилцахад агуулгын хувьд зөвхөн МУТСТ харилцагчийг таньж мэдэх талаар тусгасан байна. Энэ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар заасан МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт тусгах асуудлыг бүрэн агуулаагүй гэж үзнэ.

**ББСБ №2:** Нэр бүхий ББСБ нь газар дээрх хяналт шалгалтын үеэр МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр баталсан хэмээн эх хувийн гаргаж өгсөн. Ажлын хэсгийн зүгээс тухайн хөтөлбөртэй танилцахад хөтөлбөр нь тухайн оны МУТСТ чиглэлээр хийхээр төлөвлөсөн үйл ажиллагааны хөтөлбөр хэлбэртэй байсан ба энэ нь мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар заасан МУТСТ дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт тусгах асуудлыг бүрэн агуулаагүй гэж үзэх үндэслэл болно.

**Зөрчигдсэн хууль тогтоомжийн заалт нь:**

Дээрх 2 ББСБ-ын тохиолдолд харилцан адилгүй нөхцөл байдалд байгаа ч ерөнхийдөө дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хуульд нийцүүлэн батлаагүй гэж үзэх үндэслэлтэй байна. Үүссэн нөхцөл байдал, нотлох баримт, СЗХ-нд ирүүлж байсан баримт материал болон тухайн баталсан гэх хөтөлбөрт дүн шинжилгээ хийгдсэний үндсэн дээрээс шаардлага хангаагүй гэж үзвэл өмнөх тохиолдолтой адилаар Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 19.1-д мэдээлэх үүрэгтэй этгээд нь дотоод хяналтын хөтөлбөр баталж бүртгүүлээгүй нь хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасны дагуу тухайн ББСБ-г 5 сая төгрөгөөр торгох үндэслэл бүрдсэн байна.

# 4

## БҮЛЭГ

### ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 4.1. Эрсдэлийн тухай ойлголт, яагаад үнэлэх хэрэгтэй вэ?

Эрсдэл гэдэг нь гадаад болон дотоод орчны нөлөөллөөс үүсэн хувь хүн, байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг үр дагавар юм. Эрсдэлийг үүсэх шалтгаан, учрах нөлөө, тохиолдох давтамж, учруулж болох хохирол зэрэг шинж чанартай байна. Эрсдэлийг хэзээ, хаана, ямар хэмжээний эрсдэл учрахыг урьдчилан тодорхойлоход бэрхшээлтэй, эрсдэлийн цаана шалтгаан үр дагавар харилцан адилгүй байдаг.

МУТС нь улс үндэстэн, санхүүгийн болон санхүүгийн бус салбарт үзүүлэх нөлөө асар өндөр бөгөөд энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр шат дараалсан, олон талт арга хэмжээг хэрэгжүүлж Үндэсний, Салбарын, МҮЭ-дийн эрсдэлийг үнэлдэг байна.

ФАТФ-ын зөвлөмж болон олон улсын туршлагаас авч үзэхэд МУТС эрсдэлийг өөр өөр өнцгөөс нь авч үзсэн эрсдэлийн үнэлгээний гурван төвшинд авч үзсэн байдаг. Эдгээр гурван үнэлгээ нь хамтдаа МУТСТ-д туслах боломжит эрсдэлийн талаарх мэдээллийг төр засаг, эрх бүхий байгууллага, МҮЭ-үүдэд өгөхөөс гадна цаашлаад улс орны бодлого тодорхойлолт, МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, МУТС болзошгүй эмзэг байдал, аюул заналаас зайлсхийх боломжийг бүрдүүлдэг байна

Дүгнэхэд, бүх шатанд эрсдэлийн үнэлгээг хийх нь МУТСТ үйл ажиллагааны хүрээнд хамгийн үр дүнтэй арга юм. Эрсдэлийн үнэлгээг мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүрээнд, зохицуулагч байгууллагын хүрээнд /салбарын/, Үндэсний хүрээнд /бүх МҮЭ/ үнэлж, дүгнэдэг бөгөөд үүний үр дүнд эрсдэлийг илрүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах зэрэг богино болон урт хугацааны арга хэмжээг авч ажилладаг.

#### 4.2. Үндэсний эрсдэлийн үнэлгээ

ФАТФ-ын МУТСТ олон улсын стандарт /ФАТФ-ын Техникийн 40 зөвлөмж/-ын хүрээнд улс орнууд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй.

ҮЭҮ зорилго бол Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгох, хууль сахиулах, зохицуулах, урьдчилан сэргийлэх байгууллагуудын хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилах, оновчтой

арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар тус эрсдэлийг бууруулахад оршино.

ҮЭҮ нь Монгол Улсад бүхэлд нь нөлөөлж буй МУТС асуудлыг авч үзнэ. Дотоодын болон олон улсын аль алиных нь төрийн байгууллагаас гаргасан мэдээлэл нь мөн ҮЭҮ-нд ашиглагдах бөгөөд аюул занал, гэмт хэргийн хандлагын өргөн хүрээтэй дүр зургийг харуулдаг. МҮЭ-үүд ҮЭҮ-г ашиглан тулгарч буй аюул занал, хандлагын талаар мэдээлэлтэй болох ёстой. СЗХ-нд болон бусад эрх бүхий байгууллагуудын МУТС сургалт хариуцсан ажилтнууд холбогдох кэйс судалгаа, бүртгэгдсэн хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг сургалт, сурталчилгааны ажилд ашиглах хэрэгтэй. Олон улсын туршлагаас харахад МУТС-д хүргэдэг гэмт хэргийн мөн чанарыг ойлгосон ажилтнууд МУТС үйлдлийг олж илрүүлэх, таслан зогсоох хүсэл эрмэлзэл өндөртэй байдаг болохыг олж тогтоожээ.

Монгол Улс анх 2016 онд ҮЭҮ-г хийсэн 2 дахь үнэлгээг 2020 онд Дэлхийн банкны аргачлалын дагуу үнэлж байгаа бөгөөд ҮЭҮ-ний үнэлгээгээр салбар бүрийн эрсдэлийг тодорхойлох, ирэх 3-4 жилд Монгол Улсын МУТС чиглэлээр баримтлах бодлогын баримт бичиг буюу Үндэсний хөтөлбөр батлахад ач холбогдол нь оршино.

Батлагдан гарах Үндэсний хөтөлбөр нь ФАТФ-ын техникийн хэрэгжилтийн 40 зөвлөмжийн зөвлөмж тус бүрээр тулгарч болзошгүй асуудал, учирч болох эрсдэл, шийдвэрлэх арга зам зэрэг бүх асуудлыг тодорхойлох томоохон бодлогын бичиг баримт бөгөөд зохицуулагч байгууллага, МҮЭ-ийн МУТС үйл ажиллагааны гол цөм болдог байна.



### 4.3. Салбарын эрсдэлийн үнэлгээ

МУТС эрх бүхий байгууллагууд нь хариуцсан салбаруудынхаа эрсдэлийн үнэлгээг гаргадаг. Эдгээр байгууллагаас гаргах МУТС салбарын эрсдэлийн үнэлгээ нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа МҮЭ-үүдийн ойлголтыг сайжруулах, эрсдэлийн үзүүлэлтүүд, хандлага, тулгамдаж буй

асуудлын талаар мэдээлэл өгөх, тухайн салбарт үйл ажиллагаа явуулахад МУТСТ төрөлхийн эрсдэл ямар төвшин байгаа болох, эрсдэлийн хэрхэн бууруулах арга замыг тодорхойлох зорилготой.

ФАТФ-ын техникийн болон шууд хэрэгжилтийн зөвлөмж, үүрэг даалгаврын хүрээнд СЗХ 2018 онд МУТС салбарын эрсдэлийн үнэлгээг анхлан хийсэн. Үнэлгээний багаас 2019 онд ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд дахин сайжруулах, шинэчлэн хийх шаардлага үүсэж байсан.

Үүний дагуу 2019 онд СЗХ-ны зохицуулалтын санхүүгийн болон санхүүгийн бус санхүүгийн салбарын МУТС эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна. ҮЭҮ болон салбарын эрсдэлийн үнэлгээ нь харилцан хамааралтай бөгөөд ҮЭҮ-ээс гарах үр дүнгээс хамаарч салбарын эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт орох боломжтой. Нөгөөтэйгүүр МҮЭ-ийн эрсдэлийн үнэлгээ мөн салбарын эрсдэлийн үнэлгээнд нөлөөлж болно.

#### 4.4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн үнэлгээ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар МҮЭ нь МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлэх шаардлагатай.

МҮЭ-ийн эрсдэлийн үнэлгээ 2 хэлбэртэй байх ба нэг талаас МҮЭ нь дотооддоо эрсдэлийг үнэлэх бол нөгөө талаас зохицуулагч байгууллага нь тухайн МҮЭ-ийн эрсдэлийн үнэлж байдаг байна.



#### **ББСБ-ны МУТС эрсдэлийн үнэлгээ**

**ББСБ нь өөрийн үйл ажиллагаандаа МУТС эрсдэлийн үнэлгээг хийх ёстой:** Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 2.1-д “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дэх хэсэгт заасан дотоод хяналтын

хөтөлбөрөө өөрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд тохирч байгаа эсэхийг байнга үнэлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг хүргэх хэлбэр, газар зүйн байршил болон харилцагчийн төрлөөс хамаарах эрсдэлийг удирдахад тохируулан шинэчилнэ.” гэж заасан байдаг.

ББСБ нь өөрт учирч болзошгүй МУТС эрсдэлийг ойлгож, үр дүнтэй удирдах зорилгоор эрсдэлийг үнэлэх ба дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл /энэ нь ББСБ-ны тусгай зөвшөөрөлтэй эрхэлж буй үйл ажиллагааг хамааруулан үзэх бөгөөд тухайн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрөл, онцлогийг харгалзан үзэх шаардлагатай/;
3. Газар зүйн байршил, бүс нутгийн эрсдэл (тухайн ББСБ-ны үйл ажиллагаа оршин байгаа болон харилцагчийн үйл ажиллагаа явуулж байгаа эсхүл гүйлгээг шилжүүлж байгаа болон хүлээн авч байгаа бүс нутаг);
4. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;
5. Дансны төрөл эсхүл бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл;
6. Гүйлгээтэй холбоотой эрсдэл (үүнд харилцагчийн гүйлгээний болон байршуулж байгаа хөрөнгийн хэмжээ, гүйлгээний давтамж болон санхүү, бизнесийн харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн хугацаа, гүйлгээний утга, хэмжээ хэвийн бусаар өөрчлөгдсөн эсхүл өндөр эрсдэлтэй улсаас хийгдсэн, дамжсан зэргийг анхаарна).

ББСБ нь дээр дурдсан эрсдэлийн хүчин зүйлсийн үнэлгээг хийж, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бол МУТС эрсдэл нь арай өргөн цар хүрээтэйгээр авч үзэгдэх шаардлагатай бөгөөд өөрийн ББСБ-нд ирээдүйд үүсэх болон одоо тохиолдож байгаа эрсдэлийг тооцоолон үнэлэх шаардлагатай билээ.

ББСБ нь МУТС дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр боловсруулахдаа үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээ болон МУТС чиглэлээр ялангуяа ФАТФ болон АНДМУТБ-ээс гаргасан гарын авлага, зааварчилгаа, мөн СЗХ, СМА бусад эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмжийг ашиглах хэрэгтэй.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д СЗХ нь ББСБ-уудын энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ба эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Түүнчлэн мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т СЗХ нь зөвхөн ББСБ бус зохицуулалттай бүх МҮЭ-дэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж заажээ. Үүний дагуу холбогдох ББСБ-аас СЗХ-нд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ББСБ тус бүрээр МУТС эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацааны давтамжтай хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн зайны болон газар дээрх хяналт шалгалт явуулж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг болно. Тухайлбал:

1. МУТС эрсдэлийн үнэлгээний эрсдэлийн оноо өндөр гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаарх тайлбар, тодруулга авах, нэмэлт баримт материал шаардах;
2. МУТС эрсдэлт хүчин зүйлсэд хяналт тавьж ажиллах талаарх холбогдох ББСБ-д заавар, зөвлөмж хүргүүлэх;
3. Шаардлагатай тохиолдолд сануулга өгөх, УБАШ, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Тухайлбал, тухайн ББСБ-г газар дээрх шалгалтад хамруулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

**Анхааруулахад:** СЗХ-ны эрсдэлд суурилсан зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүнд үндэслэн авч буй холбогдох арга хэмжээ гэдэгт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг авдаг байна. Үүнд:

- Тухайн гаргасан зөрчил, дутагдлаас хамаарч дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;
- ББСБ-ын зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;
- Эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох гэх зэрэг багтдаг

Харин гаргасан зөрчил дутагдал нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил

*мөн бол тус хуулийн дагуу торгууль, шийтгэл ногдуулах цаашлаад гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэдэг байна.*

### **Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг хэрхэн үнэлдэг вэ?**

СЗХ нь ББСБ, бусад МҮЭ-ийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ шинэ тутамд гарч буй өөрчлөлт, олон улсын арга аргачлалыг зохицуулалттай салбарын онцлогт тохируулан, тухайн цаг үеийн байдлаас шалтгаалан, тухай бүр өөрчлөлт оруулан хийдэг бөгөөд ерөнхий 3 төрлөөр эрсдэлийг үнэлсний дараагаар тухайн ББСБ-ын нэгдсэн үнэлгээг гарган эрсдэлийн төвшинг тогтоодог байна. Үүнд:

**Байгууллагын бүтцийн эрсдэл:** Үүнд ББСБ-ын хэмжээ, цар хүрээ, харилцагч, ажилчдын тоо, эзэмшлийн хэлбэр, үйл ажиллагаа явуулсан хугацаа зэрэг багтана.

**Байгууллагын бизнесийн эрсдэл:** Үүнд тухайн байгууллагын харилцагчдын төрөл, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл, хүргэх сүвгийн эрсдэл, газар зүйн байршлын эрсдэл зэргийг харгалзаж эрсдэлийг тооцдог

**Комплаенсын эрсдэл:** Үүнд тухайн байгууллагын засаглал, удирдлагын зүгээс хэрхэн анхаарал хандуулдаг эсэх, Дүрэм журмын хүрээнд хэрхэн боловсруулж, мөрддөг эсэх, өөрийн байгууллагын эрсдэлийг хэрхэн үнэлж, эрсдэлд тохирсон арга хэмжээ авдаг талаар болон дотоод хяналтын хөтөлбөртэй холбоотой асуулгуудаар дүгнэдэг.

СЗХ нь МҮЭ-ийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ хугацааны давтамжтайгаар явуулах буюу /хагас жилд тутам/ бөгөөд тухайн ББСБ-ны үйл ажиллагаанд томоохонд тооцогдох өөрчлөлт гарсан тохиолдолд, ББСБ-аас СЗХ-нд ирүүлсэн МУТСТ чиглэлээр хийсэн үйл ажиллагааны тайлан, СЗХ-нд өгч буй шаардлагыг хэрхэн биелүүлж байгаа зэрэг хяналт шалгалтын үр дүнг үндэслэн тухай бүр ББСБ-ын эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт орж байдаг байна.

### **4.5. Эрсдэлийн удирдлага, эрсдэлд суурилсан аргачлал**

МУТС эрсдэлийн удирдлага гэдэг нь тухайн ББСБ-ын МУТС эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зөв зохистой явуулахыг хэлнэ.

Үүнийг хэрэгжүүлэхдээ эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглах ба энэ нь тухайн ББСБ-ын тухайн цаг үед болон ирээдүйд бий болох эрсдэлийг тодорхойлж, үүн дээр шинжилгээ хийж үнэлгээ боловсруулан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг цогц системийг ойлгоно. Эрсдэлд суурилсан аргачлал нь хязгаарлагдмал нөөц бололцоог ухаалгаар ашиглах

боломжийг бий болгож, эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорьдог. Энэ нь олон улсад нийтлэгээр ашигладаг бөгөөд өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй байдаг байна.

Хэдийгээр ББСБ-ын салбарын хууль, эрх зүйн зохицуулалтын орчин сайн бүрдсэн төдийгүй, тус салбарт мөнгө угаах эмзэг байдлыг бууруулж өгдөг хүчин зүйлс байдаг. ББСБ-ын салбар нь бусад санхүүгийн салбартай харьцуулахад зах зээлийн хэмжээ бага байхаас гадна бусад санхүүгийн салбартай харьцуулахад өвөрмөц салбар билээ. Гэсэн хэдий ч МУТС эрсдэл, мөнгө угаах эмзэг байдал багатай ч огт эрсдэлгүй гэсэн үг биш бөгөөд эрсдэлд өртөх боломжтой болохыг анхаарах хэрэгтэй.

МУТС эрсдэлийг удирдах үйл явц нь ББСБ-ын ажилтнуудын хамтын оролцоотой хэрэгжих бөгөөд энэ нь шат дараалсан хяналттай байна. ББСБ-ын МУТС эрсдэл тохиолдож болох хүчин зүйлсийг дараах байдлаар ангилна.

#### **4.5.1. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл**

ББСБ нь хадгаламж, зээлийн хоршооноос ялгаатай нь дотоодын бөгөөд гадны харилцагчдад үйлчилгээ үзүүлэх боломжтой. ББСБ-уудын хувьд олон төрлийн харилцагчдад үйлчлэх боломжтой тул эрсдэлийг харгалзан үзэхдээ анхаарал, болгоомжтой хандах шаардлагатай. Харилцагчаас хамаарч үүдэх эрсдэл гэдэг нь харилцагчаас үүсэх МУТС ерөнхий эрсдэл юм. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлсноор тухайн бизнестэй холбоотой этгээдүүдийг үнэлэх, цар хүрээг тодорхойлоход тусалдаг.

Тус эрсдэлд ББСБ нь харилцагчаа бүрэн таньж мэдэлгүйгээр түүнд үйлчлэх, улмаар хууль бус хөрөнгийг ББСБ-д байрших, банк санхүүгийн системээр дамжуулах эрсдэлтэй.

Харилцагчийн эрсдэлийн түвшнийг доор заасан хүчин зүйлүүдийг харгалзан тогтоож болно:

- Улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл холбоо хамааралтай эсэх;
- Эцсийн өмчлөгчийг тогтоох;
- Харилцагчийн эрхэлдэг үйл ажиллагааны төрөл, цар хүрээ;
- Харилцагчийн орлогын эх үүсвэр;
- Харилцагчийн авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл;
- Харилцагч оршин суугч бус, гадаадын иргэн эсэх.

ББСБ нь хуулийн этгээдийн эзэмшлийн хэлбэр, хувьцаа эзэмшигчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох шаардлагатай. Харилцагч хуулийн этгээд нь нарийн төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд байх, эцсийн өмчлөгч эсхүл хуулийн этгээд нь биечлэн ирэхгүй байх зэрэг нь харилцагчаас

хамаарч үүсэх эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс болохыг анхаарах хэрэгтэй.

ББСБ-ууд нь МУТС эрсдэлд өртөх боломж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бөгөөд шаардлагатай тохиолдолд дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### **4.5.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл**

ББСБ нь дэвшилтэт технологид суурилж өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч амар хялбар, түргэн шуурхай үзүүлэх байдлаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, финтек салбарт ихээхэн үүргийг гүйцэтгэж байна. Ингэхдээ ухаалаг гар утас, цахим аппликэшн зэрэг цахим хэрэгслээр дамжуулж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд эрсдэл энэ хэмжээгээр нэмэгдэнэ.

Түүнчлэн ББСБ-уудын үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, түүний төрлөөс хамааран МУТС эрсдэл харилцан адилгүй, ялгаатай байна. Тухайлбал, олон улс болон эрсдэлийн үнэлгээгээр бүтээгдэхүүн үйлчилгээний шинж чанараас хамааран цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, итгэлцэл, гадаад валютын арилжаа зэрэг нь харьцангуй өндөр эрсдэлтэйд тооцогдож байна. Түүнчлэн олон төрлийн нэмэлт зөвшөөрлийг авч үйлчилгээ үзүүлэх болон ганц төрлийн үйлчилгээг үзүүлэх нь эрсдэлийн хувьд өөр хоорондоо ялгаатай байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарах эрсдэл гэдэг нь ББСБ-ын харилцагчиддаа хүргэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг МУТС зорилгоор ашиглах боломж, эмзэг байдлын илэрхийлэл юм. Бүтээгдэхүүн, үйлчилгээ гэдэгт нь ББСБ-ын СЗХ-нд олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хамааруулан үзнэ. ББСБ нь харилцагчиддаа бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгохын өмнө МУТС үйл ажиллагаанд ашиглагдаж болох эрсдэлтэй эсэхийг үнэлэх хэрэгтэй бөгөөд МУТС эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү хяналт тавих шаардлагатай.

МУТСТ үйл ажиллагаанд бэлэн мөнгөөр гүйлгээ хийх боломжид бүтээгдэхүүн, үйлчилгээ нь төрөлхийн эрсдэлтэй гэж үзэх бөгөөд тухайн МҮЭ нь эрсдэлийг бууруулахад чиглэсэн дотоод үйл ажиллагааны үндсэн дээр бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарах эрсдэлийг бууруулж, МУТС-ээс хамгаалах боломж бүрддэг байна.

#### **Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарах эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс:**

- Эцсийн өмчлөгчийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас нуун

далдлах боломжийг бүрдүүлж буй үйлчилгээ;

- Шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Харилцагчийн талаар хангалттай мэдээлэл авахгүйгээр хийх боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхэд харилцагчийг таньж мэдэх шаардлагыг хангалттай хэрэгжүүлэх боломжийг хангаж байгаа эсэх;
- Баталгаажуулалт хийхгүйгээр харилцагчид үзүүлж болох бүтээгдэхүүн, үйлчилгээ.

ББСБ нь холбогдох хууль тогтоомжоор заасан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэмж авах бүрд тухайн зөвшөөрлийн дагуу харилцагчид үзүүлж болох бүтээгдэхүүн, үйлчилгээ нь МУТС зорилгоор ашиглагдаж болох эрсдэлийг тооцох бөгөөд шаардлагатай тохиолдолд дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### **4.5.3. Газар зүйн байршил, бүс нутгийн эрсдэл**

ББСБ нь үйлчилгээ үзүүлэхдээ хуулийн этгээд, хувь хүний оршин суугаа хаягаас гадна эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээдийн оршин суугаа хаяг, ялангуяа хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан улс орныг судалж, МУТС эрсдэлтэй улс орноос гаралтай эсэхийг үнэлэх хэрэгтэй.

Харин харилцагч хуулийн этгээдийн хувьд тухайн хуулийн этгээдийн эзэмшигч, үүсгэн байгуулагдсан улс орон, эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн иргэншил гэх зэргийг эрсдэлийн үнэлгээ хийхдээ харгалзан үзэх шаардлагатай.

ББСБ нь дотооддоо эрсдэлийн үнэлгээ хийж, түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан, тухай бүр шинэчлэн хадгалах бөгөөд СЗХ эрх бүхий байгууллагаас шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгана.

Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдана. Тухайлбал:

- Харилцагч түүний эцсийн өмчлөгч, ашиг хүртэгч этгээд болон тэдгээрийн гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах;
- Харилцагч түүний эцсийн өмчлөгчийн талаар хангалттай мэдээлэлтэй байх шаардлагатай. Энэ хүрээнд ББСБ нь эрсдэл өндөртэй, шаардлагатай тохиолдолд үүсгэж буй бизнесийн харилцааны зорилго, хөрөнгө, орлогын гарал үүсэл, харилцагчийн эрхэлдэг ажил үйлчилгээ, бизнесийн цар хүрээний талаар мэдээлэл гаргуулж авах;
- Өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ,

гүйлгээ гэх мэт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх;

- Харилцагчийн өгсөн мэдээлэл, явц дунд олж авсан мэдээлэл, гүйлгээ нь тухайн харилцагчийн талаарх холбогдох мэдээлэл болон хөрөнгө, орлогын эх үүсвэрийн мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих;
- Шаардлагатай тохиолдолд дотооддоо баталсан дүрэм, журамд өөрчлөлт оруулах, эрх бүхий зохицуулагч байгууллагатай санал солилцох, зөвлөмж авах



#### 4.6. Жишээ, тохиолдол

**Жишээ 1:** Дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулахдаа эрсдэлийг үнэлээгүй

Нэр бүхий ББСБ нь МУТС, ҮОХЗД эрсдэлийн үнэлгээг хийгээгүй бөгөөд дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулж, ТҮЗ-р батлуулан СЗХ-нд хүргүүлсэн. Тухайн дотоод хяналтын хөтөлбөрт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан бүрдэл иж бүрэн бөгөөд дэлгэрэнгүй тусгагдсан байв. СЗХ-ны эрх бүхий албан тушаалтан нь уг мэдээ, баримттай танилцахад хэд хэдэн төрлийн алдаа гаргасан болохыг тогтоосон байна. Үүнд:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод хяналтын хөтөлбөр нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон журам зааварт нийцсэн хэдий ч эрсдэлийн үнэлгээг хийлгүйгээр дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулсан. Ингэснээр тухайн ББСБ нь өөрийн эрсдэлийн түвшинд дүйцэхүйц, эрсдэлийг хаах, багасгахад чиглэсэн, өөрийн үйл ажиллагаатай уялдсан дотоод хяналтын хөтөлбөр боловсруулаагүй байна.
2. Тухайн ББСБ нь цөөн тооны харилцагчидтай, зээлийн үйлчилгээ үзүүлдэг

бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээг бага, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах зэрэг гэмт хэрэг үйлдэгдэх боломжгүй тул эрсдэлийг үнэлэх шаардлагагүй, эрсдэлгүй гэж үнэлсэн. Ингэснээр тус ББСБ нь хууль тогтоомжид заасны дагуу эрсдэлийг үнэлээгүй, эрсдэлд нөлөөлөх 4 хүчин зүйл болон харилцагч, газар зүйн байршил, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг хүргэх сувгийн нөлөөллийг үнэлээгүй байна.

Үүнтэй холбоотойгоор СЗХ-ноос тухайн ББСБ-д дээрх алдаа, дутагдлыг залруулах зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн.

## **Жишээ 2:** МУТС эрсдэлийн үнэлгээг шинэчлээгүй

Нэр бүхий ББСБ нь анх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа буюу 5 жилийн өмнө зээлийн үйлчилгээг үзүүлдэг, бага хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байсан. Тус ББСБ нь үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ өөрийн МУТС эрсдэлийг “бага” хэмээн өөрийн аргачлалаар 4 хүчин зүйлийг харгалзан үнэлж, түүнд тохирсон дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулсан. Үүнээс хойш тус ББСБ үйл ажиллагаагаа тэлж, өргөжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ, итгэлцэл, гадаад валютын арилжаа зэрэг нэмэлт үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан. Үүний сацуу тус ББСБ нь уламжлалт зээлийн үйлчилгээг дэвшилтэт технологид суурилж финтек хэлбэрээр үзүүлж эхэлсэн. Мөн тус ББСБ нь өөрийн салбар, төлөөлөгчийн газруудыг шинээр байгуулж, үйл ажиллагаагаа тэлсэн. Гэвч 5 жилийн өмнө үнэлсэн эрсдэл буюу “бага” түвшинд эрсдэлийг ойлгож, томоохон өөрчлөлтүүд гарсан хэдий ч эрсдэлийн үнэлгээг шинэчлээгүй.

СЗХ-ноос дээрх алдаа, дутагдлыг залруулахтай холбоотойгоор МУТС эрсдэлийн үнэлгээг шинэчлэх, томоохон өөрчлөлт гарахад эрсдэлийн үнэлгээг шинэчилэх шаардлагатай талаар анхааруулж, эрсдэлийн үнэлгээг шинэчилж, ирүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн.

# 5

## БҮЛЭГ

### ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, ГҮЙЛГЭЭГ ТАЙЛАГНАХ

#### 5.1. Харилцагчийг таньж мэдэх тухай, хялбаршуулсан болон нарийвчилсан үйл ажиллагаа

ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээр хүлээсэн үүргийн хүрээнд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй байдаг. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа нь мэдээллийг баталгаажуулан тухайн харилцагчтай холбоотой эрсдэлийг тодорхойлохоос эхэлнэ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд харилцагчийг таньж мэдэх шаардлагыг зохистой хэрэгжүүлэх зорилгоор харилцагчийг тодорхойлох, харилцагчийн мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагаанд заасан шаардлагын дагуу 1) Харилцагч нь хувь хүн 2) Харилцагч нь хуулийн этгээд 3) Харилцагч хуулийн этгээдийг төлөөлж байгаа зэргээс хамааран ялгаатай байдлаар хийнэ. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг доорх тохиолдолд авч хэрэгжүүлэх үүрэгтэй:

- Бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;
- Дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
- Харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол;
- Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;
- Тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.

Аливаа харилцагч, эцсийн өмчлөгч, харилцагчийн бизнесийн үр шим хүртэгч этгээд, эсхүл харилцагч нь хуулийн этгээд эсхүл хөрөнгийг удирдах хэлцлийн дагуу хөрөнгийг хариуцаж байгаа бол түүнийг өмчилдөг, удирддаг эсхүл үр шим хүртэгч этгээдийг тодорхойлох, мэдээллийг шалгах, баримтжуулах зорилготой юм. Харилцагч нь олон шатлалтай өмчийн бүтэцтэй бол эцсийн өмчлөгч эсхүл удирдлагыг тодорхойлох хүртэл өмчлөлийн шатлал тус бүр дэх этгээдийг тодорхойлж, мэдээллийг нь шалгаж, баримтжуулах шаардлагатай.



Харилцагчийг таньж мэдэхийн тулд ББСБ нь дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

- Харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;
- Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;
- Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;

- Харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;
- Харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;
- Банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг авах.

ББСБ нь шинэ харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхдээ тухай харилцагчийн талаарх дээрх мэдээллүүдийг агуулсан эрсдэлийн хувийн хэрэг бүрдүүлнэ. Тухайн харилцагчийн эрсдэлийн хувийн хэрэг /профайл/-т тодорхой хэмжээний өөрчлөлт орсон бол (тухайлбал, хүлээгдэж буй дансны үйл ажиллагаа, албан тушаал эсхүл бизнесийн үйл ажиллагаанд орсон өөрчлөлт ББСБ нь харилцагчийн эрсдэлийн төвшинд дахин үнэлгээ хийж, эрсдэлийн төвшинд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох хууль, журмыг баримтлан үйл ажиллагаа явуулна.

Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой мэдээллийг тухайн харилцагчтай харилцан ярилцах, албан бичиг болон утсаар харилцах, тодорхойлолт, зарим тохиолдолд гуравдагч этгээдээс гаргасан лавлагаа эсхүл харилцагчийг таньж мэдэхэд зориулсан мэдээллийн санг өөрт агуулсан программыг үйл ажиллагаандаа ашиглах боломжтой.

Харилцагчийг таньж мэдэх хүрээнд өөрийн харилцагчийн эрсдэлийн төвшинд үндэслэн

- Стандарт буюу энгийн
- Хялбаршуулсан
- Нарийвчилсан гэх байдлаар харилцагчийг таньж мэднэ.

Хялбаршуулсан байдлаар харилцагчийг таньж мэдэхээс өмнө ББСБ нь өөрт учирч болзошгүй МУТС эрсдэлийг ойлгох, мэддэг байх шаардлагатай. Үүний тулд харилцагчийн эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл, газар зүйн байршлын эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх суваг, арга хэлбэрийн эрсдэл, бизнесийн харилцааны эрсдэл, гүйлгээний эрсдэл зэргийг харгалзан дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Эдгээр эрсдэлийн хувьд бага эрсдэлтэй, мөн Монгол Улсын Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон салбарын эрсдэлийн үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан хялбаршуулсан харилцагчийг таньж

мэдэх үйл ажиллагааг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.1, 5.2.2-т заасан хүрээнд хялбаршуулан хэрэгжүүлж болно.

Доорх байдлаар харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

- харилцагчийг тодорхойлох мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх давтамжийг багасгах,
- гүйлгээнд тавих байнгын хяналт тавих болон гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах төвшинг бууруулах.

ББСБ нь өөрийн мөнгө угаах болон терроризм санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт Мөнгө угаах болон терроризм санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.2-т заасны дагуу өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг тусгах шаардлагатай. Зөвхөн ББСБ гэлтгүй нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүд учирч болох эрсдэлийг бууруулах зорилгоор нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагч болон гүйлгээнд хийдэг.

Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд доорх арга хэмжээг авч болох бөгөөд энэ чиглэлээр хэрэгжүүлж болох үйл ажиллагааг үүгээр хязгаарлахгүй:

- Тухайн харилцагчийн эрхэлж буй ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;
- Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна; Энэ зөвшөөрөл нь харилцагчийг хүлээн зөвшөөрөх дотоод журмын хүрээнд явагдах бөгөөд энэ журамд мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс хэт өндөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах боломжтой зохицуулалтыг оруулсан байх шаардлагатай;
- Харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авах мэдээллийг эргэж хянах;
- ББСБ-ын өөрийн баталсан мөнгө угаах болон терроризм санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн

удирдлагын хөтөлбөрт тусгасан өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмын бусад шаардлагууд.



## 5.2. Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх

Өндөр эрсдэлтэй харилцагч бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах байдлаар харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд өндөр эрсдэлтэй харилцагч гэж ямар харилцагчийг хэлэх, мөн хэрхэн таньж мэдэх талаарх ойлголтыг бүрэн эзэмшсэнээр ББСБ нь харилцагчаас үүсэх эрсдэлийг бүүруулахад ач холбогдолтой.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.9-д доорх харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзэхээр заасан байдаг. Үүнд:

- Улс төрд нөлөө бүхий этгээд;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдсэний үндсэн дээр тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэхэд удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл авах шаардлагатай. Хэт өндөр эрсдэлтэй харилцагч ББСБ-д шаардлагатай мэдээллийг өгөхөөс татгалзсан

тохиолдолд бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх ёстой. Аливаа өндөр эрсдэлтэй харилцагчийн дансыг хянах давтамж, нарийвчлалыг нэмэгдүүлэх, мөн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг нягтлах хэрэгтэй.

### 5.3. Гүйлгээнд тавих хяналт, гүйлгээг мэдээлэх /БМГТ, ГТТГТ, СГТ/

ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын дагуу:

**Сэжигтэй гүйлгээний тайлан:** Харилцагчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол СМА-д Сэжигтэй гүйлгээний тайлангийн (СГТ) маягтын дагуу мэдээлнэ.

**Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан:** Харилцагчтай холбоотой 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол СМА-д Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн (БМГТ) маягтын дагуу мэдээлнэ.

**Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан:** Харилцагчтай холбоотой 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийсэн бол СМА-д Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан (ГТТГТ)-ийн маягтын дагуу мэдээлнэ.

ББСБ нь харилцагчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор мэдээлнэ. Харин 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор мэдээлнэ.

ББСБ нь “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ын хавсралтаар баталсан тайлангийн маягыг бөглөж, Санхүүгийн мэдээллийн албаны [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn) цахим шууданд файлаар хавсарган илгээнэ. Тайлан илгээхдээ тайлангийн маягт бүхий файлыг нууц үгээр хамгаалж, нууцлал аюулгүй байдлыг хангана. Нууц үгийг СМА-ны тайлан, мэдээлэл хүлээн авах ажилтанд утсаар мэдэгдэх шаардлагатай. СГТ, БМГТ, ГТТГТ ирүүлэхдээ тайлангийн маягыг энэ заавар, зөвлөмжийн дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөж мэдээлэх нь чухал.

Эдгээр тайланд холбогдсон харилцагч, болон бусад этгээдэд тайланд холбогдох аливаа мэдээллийг бэлтгэсэн, мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа

талаар хуульд заасан эрх бүхий байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас бусад этгээдэд мэдэгдэх, дамжуулах мөн задруулахыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу хориглодог тул тайлан илгээх явцад үүнийг сайтар анхаарах шаардлагатай.



#### 5.4. Сэжигтэй үйлдэл, сэжигтэй гүйлгээ

Сэжигтэй үйлдэл гэдэг нь тухайн харилцагчийг сэжигтэй гэж үзэх үндэслэл болсон дотоод итгэл үнэмшлээс эхэлдэг тул сэжигтэй үйлдлийг таних, нотлох амаргүй байдаг. Сэжигтэй гүйлгээ эсвэл үйл ажиллагаа нь ихэнхдээ хууль эрх зүй, эдийн засгийн болон санхүүгийн бодит үндэслэлгүй, мөн мөнгөн дүн, цаг хугацаа зэрэг нь харилцагчийн мэргэжлийн болон бизнесийн онцлог, хэв шинжтэй нийцэхгүй байх зэрэг онцлог шинж чанартай байдаг.

ББСБ болон бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс ирүүлж буй сэжигтэй гүйлгээ нь тухайн сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагааг судлах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн гол эх сурвалж болдог. Мөн сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа нь нэг гүйлгээгээр хийгдсэн үү эсхүл хоорондоо холбоо бүхий хэд хэдэн гүйлгээгээр хийгдсэн үү гэх зэрэг тодорхой мэдээллүүдийг өгдөг.


Сэжигтэй гүйлгээ нь ихэвчлэн харилцагчийн өмнө хийж хэвшсэн гүйлгээ, үйл ажиллагаа, хувийн хэрэг эсхүл ажил, мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцээгүй гүйлгээ байдаг. ББСБ-ын ажилтан нь харилцагч яг ямар гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа хийж байгааг мэдэх боломжгүй байх нь бий. Гэхдээ гүйлгээнүүд болон тэдгээрийг хийж байгаа арга хэлбэрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой танигдсан типологи, арга хэлбэр, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдэгтэй тохирч байгаа эсэхийг ажиглаж шалгаснаар аль нэг төрлийн гэмт хэргийн шинжтэй байгааг таамаглаж, сэжиглэж болно. Гүйлгээ нь дангаар

нь авч үзэхэд сэжиг төрүүлэхгүй боловч цогцоор нь авч үзэхэд гэмт хэргийн шинжтэй байх боломжтой олон төрлийн хүчин зүйлстэй холбоотой байх нь ч бий.

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад олж авч чадах баримт мэдээлэл буюу харилцагчийн хувийн хэрэг, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн түүх, өмнө хийж байсан гүйлгээний түүх зэрэг мэдээллийг цуглуулах нь сэжигтэй гүйлгээг таньж, илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Сэжигтэй гүйлгээний тайланг илгээхдээ яагаад тухайн харилцагч, гүйлгээг сэжиглэх болсон талаар тайлбарыг өгөх ба энэ нь үндэслэлтэй байх шаардлагатай байдаг. Сэжиглэх тодорхой үндэслэлгүйгээр зөвхөн өндөр дүнтэй гүйлгээ хийж байгаа гэх нь сэжиглэх хангалттай үндэслэл болохгүй юм. Харин харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон өмнө хийж хэвшсэн гүйлгээний талаарх мэдээлэлтэй нийцэхгүй байгаа өндөр дүнтэй гүйлгээг сэжигтэй гэж үзэх боломжтой.

Харилцагчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол СМА-д Сэжигтэй гүйлгээний тайлангийн (СГТ) маягтын дагуу мэдээлнэ. ББСБ-ууд нь харилцагчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор мэдээлнэ.



## ШИНЖ ТЭМДГҮҮД

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, бизнесийн харилцаа тогтоож, үйл ажиллагаа явуулах явцад энд жагсаасан сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүдийг ажиглаж болно. Эдгээр жагсаалтыг зөвхөн

жишээ, мэдээлэл байдлаар ашиглах бөгөөд сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүд нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу.

#### *Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой шинж тэмдгүүдийн жишээ:*

- Данс нээхдээ эсвэл үйлчилгээ авахдаа харилцагч ББСБ-аас шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, эсвэл төөрөгдүүлсэн, тодорхойгүй, шалгахад хэцүү мэдээлэл өгөх;
- Харилцагчийн гүйлгээний талаар өгч буй мэдээлэл, тайлбар нь авцалдаагүй, нөхцөл байдлаас зөрүүтэй байх;
- Харилцагчийн санхүүгийн байгууллагад нээлгэсэн дансны эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл худал, зөрчилтэй, төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгөх;
- Харилцагчийн өгсөн хаяг, төрсөн огноо, утасны дугаар гэх мэт мэдээлэл харилцагчийн бичиг баримт эсвэл өөр мэдээллийн эх үүсвэр дэх мэдээллээс нь зөрөх;
- Ижил төстэй гүйлгээ хийдэг хоорондоо харилцаа холбоогүй мэт харагдах олон харилцагч ижил хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг ашиглах;
- Харилцагчийг бүрэн, гүйцэд таньж мэдэх боломжгүй эсвэл харилцагчийг тодорхойлох бичиг баримт, мэдээллүүд эргэлзээтэй;
- Харилцагчийн авчирсан, үзүүлсэн баримт бичгийг баталгаажуулах боломжгүй (жишээлбэл, гадаад улсад олгогдсон бичиг баримтын хуулбар г.м);

#### *Санхүүгийн гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүдийн жишээ:*

- Харилцагчийн дансны үйл ажиллагаа, гүйлгээний дүн, давтамж нь харилцагчийн ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, үйл ажиллагааны ердийн хэв маягтай нийцэхгүй байх (жишээлбэл, харилцагч нь оюутан, ажилгүй, тэтгэвэрт гэх мэт);
- Харилцагчийн дансны үйл ажиллагаа, гүйлгээний хэмжээ нь ижил төрлийн ажил, бизнес эрхэлдэг харилцагчдаас хэт зөрүүтэй байх;
- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ нь түүний анх данс нээлгэсэн эсвэл бизнесийн харилцаа тогтоосны дараа хийж байсан гүйлгээний дундаж хэмжээ, дансны хэвшсэн үйл ажиллагаанаас огцом нэмэгдсэн;
- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ, дансны үйл ажиллагаа нь МҮЭ-д мэдүүлсэн бизнесийн төрөл, үйл ажиллагаанаас зөрүүтэй байх (жишээлбэл, байгууллагын дансаар нь цалин хөлс, нэхэмжлэх төлөх гэх мэт бизнестэй холбоотой ердийн гүйлгээ хийгдэхгүй байх);

- Харилцагчийн санхүүгийн үйл ажиллагааны хэв маягтай нь нийцэхгүй их хэмжээний мөнгийг богино хугацаанд хүлээж авах, буцааж шилжүүлэх;

#### *Хэвийн бус гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүдийн жишээ:*

- Хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, ашиглалтыг нуун дарагдуулахаар оролдож буй мэт санагдуулахуйц нарийн төвөгтэй, цуврал шилжүүлгүүд хийх;
- Харилцагч нь нэг санхүүгийн байгууллагад олон бүтээгдэхүүн, данс эзэмшдэг бөгөөд хийдэг гүйлгээнүүд нь хоорондоо авцалдахгүй, харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Гүйлгээ нь гүйлгээний утга, зорилготойгоо нийцэхгүй байх, шаардлагагүй байхад хэт нарийн төвөгтэй байдлаар хийгдэх;
- Харилцагч ердийн бус байдлаар боосон, багласан эсвэл зөөвөрлөсөн мөнгөн тэмдэгт, төлбөр тооцооны хэрэгслээр гүйлгээ хийх;
- Харилцагчийн гүйлгээ нь тодорхой бизнес, эдийн засгийн зорилгогүй байх;
- Гүйлгээ нь гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанд ашигладаг арга хэлбэр, типологитой нийцэх;
- Гүйлгээг халхавч этгээд (ямар нэг хөрөнгөгүй, үйл ажиллагаа эрхэлдэггүй, эсхүл биетээр оршин тогтнодог гэх үндэслэлгүй этгээд) хийсэн эсхүл хийх гэж байгаа бол;

#### *Гүйлгээг мэдээлэх мөн таних шаардлагаас зайлсхийх хэв шинжийн жишээнүүд:*

- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих;
- Харилцагч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээг мэдээлэгдэхээс зайлсхийх зорилгоор гүйлгээний босго дүн буюу 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-өөс бага дүнгээр олон хувааж гүйлгээгээ хийх;
- Харилцагч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээний босго дүнгээс дээш дүнтэй гүйлгээ хийхээс зайлсхийх зорилгоор бусадтай хамтарч ажиллаж буй мэт харагдах;
- Харилцагч сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаар маш сайн судалж, мэдсэн байх;

- Харилцагч гүйлгээнд оролцож буй мөнгийг “цэвэр”, “хууль ёсны”, мөнгө угаахтай холбоогүй” гэж сайн дураараа, асуугаагүй байхад шууд хэлэх;

### *Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шинж тэмдгүүд:*

- Алан хядах бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулдаг, зэвсэгт мөргөлдөөн болж байгаа эсвэл түүнтэй ойрхон байршил, мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хяналт тавих сул тогтолцоотой гэх мэт өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг руу гүйлгээ хийх;
- Олонд танигдсан эсвэл сэжиглэгдэж байгаа террорист байгууллагатай холбоотой эсвэл холбоотой байж болзошгүй хуулийн этгээд, сан, холбооны нэрээр нээлгэсэн данс, түүгээр хийгдэх гүйлгээ;
- Албан бүс эсвэл бүртгэлгүй хэлбэрээр хандив цуглуулах;
- Гүйлгээний аль нэг талд хориг арга хэмжээний жагсаалтад нэр тохирсон этгээд оролцсон;
- Хүн, хуулийн этгээдийг террорист байгууллага, террорист үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гэж хууль сахиулах байгууллагаас мэдээлсэн;
- Харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг, ялангуяа мөргөлдөөн болж буй эсвэл улс төрийн тогтворгүй байдалтай байгаа эсвэл террорист үйл ажиллагаа, байгууллагыг санхүүгийн болон бусад байдлаар дэмждэг гэдгээр танигдсан улс орон, бүс нутагтай холбоотой аялал жуулчлалын худалдан авалт хийсэн (жишээ нь, онгоцны тийз худалдан авсан, аяллын виз, паспортын төлбөр төлсөн гэх мэт);

## **5.5. Эцсийн өмчлөгчийг тогтоох**

### **Эцсийн өмчлөгч гэж хэн бэ?**

Эцсийн өмчлөгч гэж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д зааснаар дараах хувь хүнийг ойлгоно заасан. Үүнд:

- Харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- Харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн

хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

- Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг гэж тодорхойлсон байдаг.

Харилцагчийг таньж мэдэхэд хамгийн төвөгтэй бөгөөд хүндрэлтэй асуудал нь харилцагч нь хуулийн этгээд байх тохиолдолд эцсийн өмчлөгч нь хэн болохыг тогтоох байдаг. ББСБ нь эцсийн өмчлөгч, харилцагчийн эзэмшилд байгаа хөрөнгийн ашиг шимийг хүртэгч этгээд, гэрээ хэлцлийн дагуу хөрөнгийн хөрөнгөө шилжүүлэн, шийдвэр гарган удирддаг эсхүл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авах бөгөөд эцсийн өмчлөгчийг тогтоосон гэж үзэх хүртлээ найдвартай эх сурвалжаас шаардлагатай мэдээллийг авч ажиллах хэрэгтэй.

Эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно:

1. Хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг
2. 1-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг
3. 1, 2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг шалгаж тогтооно.

ББСБ болон бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүд хууль хяналтын байгууллагатай ижил хянан шалгах эрх мэдэл байхгүй учраас мэдээлээгүй эсхүл нууц эцсийн өмчлөгч байгаа эсэхийг тодорхойлохын тулд заавал хяналт шалгалт, дүн шинжилгээ хийх үүрэг хүлээдэггүй. Шинэ харилцагчтай болох эсхүл гэнэтийн ямар нэгэн гүйлгээ хийхээс өмнө холбогдох асуулгаар тухайн харилцагчийн мэдээллийг авч, өөрийн боломжит хүрээнд эцсийн өмчлөгчийг тогтоох шаардлагатай. Эцсийн өмчлөгчийг тодорхойлохоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар бүртгэл хөтөлж хэвшүүлэх нь ХТМ үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

## **5.6. Улс төрд нөлөө бүхий этгээд**

Улс төрд нөлөө бүхий этгээд гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг хэлдэг. Дараах хүмүүсийг дотоодын УТНБЭ гэж үзнэ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, сайд нар
- Дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч

агентлагийн дарга, дэд дарга нар

- УИХ-ын гишүүд
- Монголбанкны Ерөнхийлөгч болон захирлуудын зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд; Санхүүгийн зохицуулах хорооны дарга, удирдлага
- Үндсэн хуулийн цэц, Дээд болон бусад шүүхийн дарга, гишүүд, шүүгч нар
- Ерөнхий прокурор, түүний орлогчид
- Тагнуулын ерөнхий газрын дарга, түүний орлогчид
- Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нар
- Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Хуурай замын зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн командлагчид, тэдгээрийн орлогчид
- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын, прокурорын, тагнуулын байгууллагын дарга нар, давж заалдах шатны болон дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгч нар
- Төрийн өмчийн, төсвийн байгууллагуудын, дүрмийн сангийн 50-с дээш хувийг төр эзэмшиж буй эдийн засгийн түншлэлийн захиргаа, удирдлага, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжүүдийн дарга нар
- Улс төрийн намуудын удирдах зөвлөлийн дарга, намын төв аппаратын гишүүд
- Засгийн газрын агентлагийн дарга
- Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны бүрэн эзэмшилд буй компанийн захирлууд.

ББСБ нь өөрийн дотоод хяналтын хөтөлбөрт улс төрд нөлөө бүхий этгээд, түүний гэр бүлийн гишүүд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, тэдгээрийг харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаанд хамруулах, тэдгээрийн нэр дээр хийгдэж байгаа гүйлгээнд тусгайлан хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улс төрд нөлөө бүхий этгээдийг танихдаа ББСБ нь өөрт байгаа мэдээллийн бүхий л боломжит урсгалыг ашиглан дотоод жагсаалтыг баталж болно. Тухайлбал, хөрөнгө, орлогын мэдүүлэг, УИХ-ын гишүүдийн жагсаалт, олон нийтийн цахим сүлжээ гэх мэт олон төрлийн мэдээллийн сүвгийг ашиглах боломжтой. Мөн мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн харилцагчийг таньж мэдэх программ, мэдээллийн санд УТНБЭ-ийн албан бус жагсаалтыг оруулсан байдаг.

УТНБЭ-тэй бизнесийн харилцаа тогтоох буюу үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ ББСБ нь:

- Тухайн УТНБЭ-тэй холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төвшинг тогтооно
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах хяналтын зохих механизмууд байгаа эсэхийг тогтооно.

### 5.7. Жишээ, тохиолдол

**Жишээ 1:** Нэр бүхий ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх нэмэлт зөвшөөрлийг авсан бөгөөд харилцагч өндөр дүнтэй гүйлгээнүүдийг нэр бүхий иргэдийн дансанд шилжүүлсэн. Ингэхдээ гүйлгээний утга, зорилго бөгөөд хууль эрх зүйн үндэслэл, эдийн засгийн үндэслэлгүй хийгдсэн. Тухайн ББСБ нь эдгээр гүйлгээг сэжигтэй гэж үзэх эсэхийг шийдээгүй, гүйлгээг зөвшөөрсөн байна. Сэжигтэй гүйлгээний тайланг СМА-нд 24 цагийн дотор хүргүүлээгүй зөрчлийг илрүүлж, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, заавар зөвлөмжөөр хангаж ажилласан.

# 6

## БҮЛЭГ

### УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

#### 6.1. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдол

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь олон шатлалтай, илрүүлэхэд нарийн төвөгтэй, харагдах байдлаасаа энгийн мэт харагддаг боловч учруулж буй хор хохирол өргөн хүрээтэй байдаг. Тухайлбал, нийгэм эдийн засагт асар их бохир мөнгөн хөрөнгө эргэлдэх, Улс орны нэр хүнд унах, мөнгөн гүйлгээ дамжигдсан санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах зэрэг олон төрлийн сөрөг үр дагаврыг бий болгож байдаг. Үүнийг энгийн жишээгээр тайлбарлавал компьютерт нэвтэрсэн аюултай вирус гэж ойлгож болно. Харин ямарваа нэгэн вирусээс өөрийн компьютерийг хамгаалахын тулд хамгаалалтын программ суулгаж байнгын шинэчлэлт, хайлт хийж аюулгүй байдлаа хангадаг. Энэ бол ирээдүйд учирч болох ямарваа нэгэн аюулаас одоо цагт өөрийгөө хамгаалж буй үйлдэл бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үүнтэй утга ижил юм. Энэ үйл ажиллагааг “дотоод хяналтын хөтөлбөр”-өөр дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд үүнд удирдлага, албан хаагчдын (front office, back office) эрх үүрэг, тэдгээрийн холбоо хамаарал, тайлагнал, зохион байгуулах сургалт, ажилчдын шалгуур үзүүлэлт, гүйлгээг мэдээлэх, тайлагнах үүргийн хэрэгжилт гэх мэт өргөн хүрээний асуудлыг оруулах нь зүйтэй.

#### 6.2 Сургалт, мэдээлэл

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэг хэсэгт дотооддоо зохион байгуулах МУТСТ сургалт чухал ач холбогдолтой. Зохион байгуулж буй сургалтуудад удирдах албан тушаалтнаас гүйцэтгэх албан тушаалтнуудыг хамруулсан байх бөгөөд аливаа үүсч болох эрсдэлд шуурхай хариу үзүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахад чиглэсэн байх ёстой. Түүнчлэн, МУТСТ сургалтыг тодорхой цаг хугацааны давтамжтай зохион байгуулж, үр дүнг дүгнэн шалгалт авч, зөвхөн тэнцсэн албан хаагчдыг ажиллуулах нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зорилго юм.

Үүнээс гадна зохицуулалтын байгууллагаас МУТСТ чиглэлээр зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан албан хаагчид бусад албан хаагчдыг чадавхжуулах нь зүйтэй. Сургалт нь дараах агуулгыг хамарсан байвал зохино. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хянаж зохицуулах болсон талаарх ерөнхий мэдээлэл болон түүх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад болон яаж үйлдэгддэг, яагаад энэ төрлийн гэмт хэргүүдийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шаардлагатай талаарх мэдээлэл;
- Олон улсын стандарт, шаардлагууд;
- Үнэт цаасны салбарыг ашиглан Монгол Улсад болон бусад гадны улс орнуудад МУТС гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга хэлбэр, хэв шинж, типологиуд;
- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, журам болон зохицуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын гаргасан гарын авлага, заавар зөвлөмж;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох Үндэсний эрсдэлийн үнэлгээ;
- Байгууллагын эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон МУТС-тэй холбогдох эрсдэлүүд;
- ББСБ-ын дотоод хяналтын нэгж болон хяналт тавих эрх бүхий байгууллагын хийсэн хяналт шалгалтаар илэрсэн МУТСТ-тэй холбоотой асуудлууд, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- ББСБ-ын ажилтнуудын (нягтлан, зээлийн эдийн засагч, теллер, комплаенсын ажилтан, бусад ажилтнууд, ахлах ажилтан, захирал, ТУЗ гэх мэт) МУТСТ-тэй холбоотой үүрэг, хариуцлага, чиг үүргээ хэрэгжүүлэх, ажлаа хийх явцад тулгарч болох түгээмэл асуудлуудыг шийдвэрлэх арга зам.

### **6.3. Баримт материалын аюулгүй байдал**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1 болон 8 дугаар зүйлд зааснаар мэдээлэх үүрэгтэй этгээдүүд МУТС тэмцэх үйл ажиллагаанд харилцагч, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа баримт мэдээллийг хадгалж байх үүрэг хүлээдэг. Учир нь цуглуулсан баримт материалыг байгууллагын эрсдэлийг үнэлэх, хууль хүчний байгууллага шаардсан даруйд гаргаж өгөх зэрэг ач холбогдолтой байдаг.

Мөн тус хуульд зааснаар баримт материалыг 5 жил хүртэлх хугацаанд хадгалах бөгөөд олон улсын практикийн дагуу хугацаа хэтэрсэн баримт, материалуудыг хэрхэн устгах талаар дотоод хяналтын хөтөлбөрт тусгах нь зүйтэй байдаг. Түүнчлэн хадгалж буй баримтуудыг Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийн хүрээнд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

#### **6.4. Нууцлалын аюулгүй байдал**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага, албан тушаалтан нь Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн аливаа мэдээллийг хууль хүчний байгууллагаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглосон.

Мөн Санхүүгийн мэдээллийн албаны дарга, шинжээч, хянан шалгагч, ажилтан албан үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийг бусдад задруулахыг хориглосон.

#### **6.5. Анхааруулга**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй бол зөрчлийн шинжээс хамааран Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйл, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

# 7

## БҮЛЭГ

### САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

#### 7.1. Монгол Улс ба Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ

##### ***Хориг арга хэмжээ***

НҮБ-ын Дүрмийн дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл нь олон улсад энх тайван, аюулгүй байдлыг бий болгох, түүнийг сахин хамгаалахтай холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан. НҮБ-ын Дүрмийн 41-р зүйлд “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс зэвсэг, хүч хэрэглэхгүйгээр хориг арга хэмжээ болон бусад арга хэмжээ авч хэрэгжүүлж болно” гэж заасан.

Хориг арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд: Эдийн засаг, худалдааны хориг арга хэмжээ, зэвсгийн хориг, санхүүгийн хязгаарлалт, бараа бүтээгдэхүүний хязгаарлалт болон аяллын хориг гэх мэт. НҮБ-ын гишүүн улсын хувьд Монгол Улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол, түүний дотор хориг арга хэмжээ авахтай холбоотой тогтоолыг дагаж мөрдөх үүрэгтэй.

##### ***Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ***

Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол нь гишүүн улс орнуудыг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаарддаг.

Санхүүгийн хориг арга хэмжээ нь дараах хоёр төрөлтэй байна:

1. Террорист этгээд, террорист байгууллагын жагсаалтад орсон этгээдийн хөрөнгөтэй холбоотой эсхүл тэдгээрт санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлаар санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.
2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд чиглэсэн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.

Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах үндсэн дөрвөн хориг арга хэмжээний дэглэмийг удирдлага болгоно:

Терроризмтой холбоотой хориг арга хэмжээ:

- НҮБ-ын АЗ-ийн 1267/1999/тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь Аль-Кайда, Талибан болон бусад террорист байгууллагуудын эсрэг чиглэсэн)

- НҮБ-ын АЗ-ийн 1373 /2001/ тогтоол (терроризмтой тэмцэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбоотой)

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээ:

- НҮБ-ын АЗ-ийн 1718 /2006/ тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь БНАСАУ-ын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн)
- НҮБ-ын АЗ-ийн 2231 /2015/ тогтоол болон түүнтэй холбоотой дагалдах бусад тогтоолууд (Энэ тогтоол нь Иран Улсын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн)

Дээрх тогтоол, дагалдах бусад тогтоолын талаар болон тогтоолд тусгагдсан гол үүрэг, хариуцлагын талаар НҮБ-ын <https://www.un.org/securitycouncil/sanctions/information> цахим хуудаснаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

### ***Хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг, үүрэг хариуцлагын асуудал***

Монгол Улсын “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу Монгол Улсад буй хүн, хуулийн этгээд бүр санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Дээрх хууль, журмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа аливаа хүн, хуулийн этгээд, эсхүл Монгол Улсын гадна байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд бүр НҮБ-ын АЗ-өөс гаргасан эсхүл Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, гүйлгээ хийхийг хориглоно. Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-д мөн мэдээлэх үүрэгтэй этгээдэд дээрхтэй холбоотой үүрэг оноосон зохицуулалт бий.

Монгол Улс нь санхүүгийн зорилт хориг арга хэмжээний дэглэмийг дагаж мөрдөхийн тулд Засгийн газар болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн жагсаалт, холбогдох мэдээллийг үндэслэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэхүү жагсаалт нь тухай бүр шинэчлэгдэх бөгөөд [www.amlcft.mn](http://www.amlcft.mn); [www.gia.gov.mn](http://www.gia.gov.mn); [www.fiu.mn](http://www.fiu.mn) цахим хуудсанд байрласан.

### **Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүрэг**

Терроризмтой тэмцэх зөвлөл нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах эрх хэмжээтэй, Тагнуулын ерөнхий газар нь Монгол Улсад санхүүгийн зорилт хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага бол Санхүүгийн мэдээллийн

алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн тайлан мэдээлэл болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Терроризмтой тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж, аргачлалыг (гарын авлага) боловсруулж дээрх цахим хуудсанд байршуулсан болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасны дагуу санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг санхүүгийн бүх байгууллагууд, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэгжүүлнэ. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хууль тогтоомж, холбогдох дүрэм журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж тодорхой үйлчлүүлэгч, бүтээгдэхүүн, үйлчилгээнд эрсдэлээс үл хамааран зохих хянан нийцэл /Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөх/-ийн хөтөлбөр, дотоод журмыг бий болгож түүнийг дагаж мөрдөх ёстой.

#### **Тухайлбал, Мэдээлэх үүрэгтэй этгээд нь:**

- “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 5-р зүйлд заасан үүргийг биелүүлэхдээ:
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа аливаа бүх хөрөнгийг царцаах;
  - Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын өмнөөс эсхүл шууд болон шууд бус, дангаар болон хэсэгчлэн хэлбэрээр хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглох.
- Дараах асуудлаар мэдээлэх үүрэгтэй:
  - НҮБ-ын АЗ-өөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэр тохирсон;
  - НҮБ-ын АЗ-өөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэр тохирсон байж болзошгүй;
  - Хөрөнгө царцаасан тухай тус тус мэдээлэх үүрэгтэй.

Дээрхийг мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай:

- Мэдээлэл нь өөрийн мэдлэг мэдээлэл, сэжиглэсэн гэж үзсэн асуудалд үндэслэсэн байх;
- Тухайн хүн, хуулийн этгээдийн талаар авагдсан, мэдэж байгаа бүхий л мэдээллийг тусгасан байх;
- Тухайн хүнтэй холбоотой хөрөнгийн хэмжээ, хэлбэрийг тусгасан

байх;

- o Хөрөнгийг царцаасан тохиолдолд тухайн гүйлгээний талаар болон хөрөнгө царцаасантай холбоотой мэдээллийг тусгасан байх шаардлагатай.

“Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй холбоотой мэдээлэл хүргүүлэх маягт”-ыг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-д заасан хавсралтын холбогдох маягтыг татаж ашиглана.

Монгол Улсад санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний дэглэмийг зөрчих, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.10 болон 11.29-ийн холбогдох заалтын дагуу дагуу торгууль ногдуулахаас гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авна. Үүнд: эрх, тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох, удирдах албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### ***Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд зориулсан мэдээлэл***

Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд өөрийг нь жагсаалтад оруулсантай холбогдуулан жагсаалтаас хасуулах талаар хүсэлт тавих эрхтэй. Тухайн хүсэлтийг шийдвэрлэх хүртэл хугацаанд хориг арга хэмжээ хүчинтэй үргэлжилнэ. Хэрэв тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд гэж андуурсан, алдаатай нэр орсноос үүдэн түүний хөрөнгө царцаагдсан тохиолдолд, нэгдүгээрт, мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбогдож (арилжааны банк г.м) тайлбар гаргуулах эрхтэй. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчид хөрөнгө чөлөөлөхтэй холбоотой хүсэлтийг ТЕГ-т тавих талаар мэдэгдэх ёстой.

НҮБ-ын хориг арга хэмжээний жагсаалт: НҮБ-аас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтаас хасуулах тухай хүсэлтийг НҮБ-ын эрх бүхий байгууллагад тавина. НҮБ-ын эрх бүхий байгууллагын талаарх мэдээллийг НҮБ-ын албан ёсны цахим хуудаснаас харах боломжтой. Хэрэв тухайн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд нь жагсаалтад оруулахад тавигдах шаардлагыг цаашид хангахгүй болсон гэж үзвэл Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын АЗ, холбогдох Хоригийн хороонд жагсаалтаас хасуулах тухай хүсэлт гаргах эрхтэй.

Дотоодын хориг арга хэмжээний жагсаалт: Жагсаалтаас хасуулах тухай хүсэлтийг ТЕГ-т тавьж Монгол Улсын Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

# 8

## БҮЛЭГ

### ШААРДЛАГАТАЙ БУСАД

#### 8.1. Монгол Улс ба Саарал жагсаалт

ФАТФ-аас улс орнуудын МУТСТ тогтолцоонд хяналт тавьж, хуваарьт хугацаагаар харилцан үнэлгээ хийж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилладаг. ФАТФ-аас манай улсад Харилцан үнэлгээг 2006 онд хийж, 2007 онд Монгол Улсын МУТСТ чиглэлээрх Харилцан үнэлгээний тайлан хэвлэгдэн гарсан. Харилцан үнэлгээний тайлангийн үр дүнгээс хамаарч ФАТФ-аас тухайн улс орны МУТСТ тогтолцоог сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Тухайлбал ФАТФ-аас зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, хамтран ажиллахаас татгалзсан улс орнуудыг албан бус нэршлээр “хар жагсаалт”, зөвлөмжийн биелэлт хангалтгүй, стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй орнуудыг албан бус нэршлээр “саарал жагсаалт”-д оруулж ажилладаг. ФАТФ-ын саарал жагсаалтад орсноор гүйлгээ саатах, удаашрах, олон улсад улс орны нэр хүнд унах, гадны хөрөнгө оруулагчдыг алдах, өөр бусад хориг, жагсаалтад орж болзошгүй болох зэрэг аюул тулгарах боломжтой.

ФАТФ-аас манай улсыг 2012 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа МУТСТ стратегийн дутагдалтай буюу “саарал жагсаалт”-д оруулж, 5 хугацаатай үүрэг даалгаврыг өгч байсан. Манай улс эдгээр даалгаврыг биелүүлснээр ФАТФ-аас 2014 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар саарал жагсаалтаас гаргасныг зарласан. Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар 4 Шууд хэрэгжилтийн хүрээнд 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн. Үүнд:

1. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагч байгууллагын тухайн салбарын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх, зөрчил үүссэн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах;
2. Мөнгө угаах үйлдлийг мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлэх;
3. Хилээр мэдүүлээгүй эсхүл хуурамчаар мэдүүлж нэвтрүүлсэн мөнгөн

тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах;

4. Хориг арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаас урьдчилан сэргийлж холбогдох байгууллагууд хамтран ажиллах; санхүүгийн байгууллага, Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах.

ФАТФ-с 2019 оны 10 дугаар сард дээрх үүрэг даалгавруудыг шүүрхай хэрэгжүүлж ажиллах чиглэлээр эрх бүхий байгууллагууд шат дараалсан арга хэмжээ авч ажилласан. Санхүүгийн зохицуулах хорооноос Шууд хэрэгжилт 3-ын хүрээнд “Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагч байгууллагын тухайн салбарын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх”, “эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх, зөрчил үүссэн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах”, Шууд хэрэгжилт 11-ийн хүрээнд “санхүүгийн байгууллага, Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах” гэсэн 3 үүрэг даалгаврыг биелэлтийг хариуцаж ажилласан.

Дээрх даалгавруудын биелэлтийг ФАТФ-т тогтмол тайлагнаж, хамгаалсан. 2020 оны 01 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотод болсон хамгаалалтаар 6 үүрэг даалгаврын 3-ын хэрэгжилтийг хангасныг мэдэгдсэн. Хэрэгжилтийг хангах шаардлагатай 3 даалгаврын биелэлтийг хангаж ФАТФ-т тогтмол хугацаанд тайлагнасан. Ковид-19 цар тахлын тархалттай холбоотойгоор ФАТФ-с хийгдэх үнэлгээний ажил хойшилж буй талаар мэдэгдсэн. Гэсэн хэдий ч манай улс үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, зайнаас, цахимаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаа үнэлүүлэх хүсэлтэй байгаагаа ФАТФ-т илэрхийлсэн. ФАТФ-с дээрх хүсэлтийг хүлээн авч, 2020 оны 5 дугаар сард үлдсэн 3 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнаж, цахимаар хамгаалсан. Үүний үр дүнд ФАТФ-с дээрх 3 үүрэг даалгаврыг манай улс биелүүлснийг мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын саарал жагсаалтад орсноос хагас жил буюу 6 сарын дараа 4 чиглэлээр өгсөн 6 үүрэг даалгаврыг амжилттай биелүүлсэн. Ингэснээр манай улсад ФАТФ-ын газар дээрх шалгалт 2020 оны 10 дугаар сард хийгдэж, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, үр дүнтэй байдлыг шалгасан. Газар дээрх шалгалт нь үүрэг даалгаврыг хариуцсан

байгууллагатай уулзаж, мэдээ мэдээллийг тулгаж баталгаажуулахаас гадна, хувийн хэвшил, зохицуулалттай байгууллагуудын МУТСТ үйл ажиллагаа, түүний үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч шалгадгаараа онцлогтой. ФАТФ-аас 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн өөрийн нэгдсэн хуралдаанаараа манай улсыг 4 чиглэлээр өгсөн 6 үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангаж, газар дээрх шалгалтыг амжилттай давснаар стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй орнуудын жагсаалтаас хассаныг зарлаж, түүхэн дэх хамгийн богино хугацаанд үүрэг даалгавруудыг амжилттай биелүүлж, шуурхай ажилласныг онцлон тэмдэглэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос Шууд хэрэгжилт 3-ын хүрээнд “Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагч байгууллагын тухайн салбарын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх”, “эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх, зөрчил үүссэн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах”, Шууд хэрэгжилт 11-ийн хүрээнд “санхүүгийн байгууллага, Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах” үүрэг даалгавруудыг богино хугацаанд, түргэн шуурхай биелүүлж ажиллахад шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажилласан. Хийгдсэн ажлуудаас товч дурдвал:

- 1) ФАТФ-ын эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлж, түүнийг боловсронгуй болгохтой холбоотойгоор СЗХ-ноос өөрийн зохицуулалттай 6 салбарт анх удаа МУТС салбарын эрсдэлийн үнэлгээг авч хэрэгжүүлж, үр дүнд салбарын төлөөлөл, оролцогчдод танилцуулж, үр дүнг байршуулсан. Ингэснээр үнэлгээний үр дүнд үнэлэлт дүгнэлт хийж, МУТСТ үйл ажиллагаанд суурь болох хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- 2) Зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээд буюу байгууллага тус бүрийн МУТС эрсдэлийн үнэлгээг авч хэрэгжүүлэн МУТС эрсдэлийг байгууллага тус бүрээр нарийвчлан тогтоож, эрсдэлийн төвшинд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан. МУТС эрсдэлийг үнэлэхдээ бүтцийн, бизнесийн болон хууль тогтоомжийг биелэлттэй холбоотой эрсдэлийг тооцож ажилласан. Бизнесийн эрсдэлийг ФАТФ-ын стандартын дагуу харилцагчдаас үүдэх, газар зүйн байршлаас үүдэх, бүтээгдэхүүн үйлчилгээ болон түүнийг хүргэх сувгаар үүдэх эрсдэлийн төрлүүдээр ангилж үнэлсэн. Үүнтэй холбоотой мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд

МУТС, ҮОХЗДТ чиглэлээрх асуулгыг улирал бүр авч, эрсдэлийг үнэлж ажилласан.

- 3) Хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохицуулалттай 6 салбарт хэрэгжүүлэх чиглэлээр эрсдэлийн үр дүнд суурилсан зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийсэн. Энэ чиглэлээр газар дээрх хяналт шалгалтыг нийт зохицуулалттай салбарын оролцогчдод хэрэгжүүлж, илэрсэн дутагдалд мэдэгдэл, Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Түүнчлэн илэрсэн зөрчилд захиргааны арга хэмжээг авах, хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн.
- 4) Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр УИХ-р батлагдсантай холбоотойгоор санхүүгийн бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу үл хөдлөх эд хөрөнгө зүүчлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад хамаарах болсон. Үүнтэй холбоотойгоор эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиудад 2020 оны 01 дүгээр сард тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.
- 5) Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид төрийн зохицуулалтад хамаарах болсонтой холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 12 дугаар сард Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах гэрээ байгуулсан. Ингэснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг илрүүлэх, тодорхойлох, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, тэдгээрийн МУТС, ҮОХЗД үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж, үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг авч хэрэгжүүлсэн.
- 6) Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх үйл ажиллагаатай холбоотой өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахтай холбоотойгоор СЗХ-ноос санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг биелүүлэх үүргийн хэрэгжилтийг хангуулж ажилласан. Тухайлбал, сургалт семинар, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд МУТС-с гадна, ҮОХЗДТ үйл ажиллагааг багтаасан бөгөөд тогтмол авдаг эрсдэлийн үнэлгээний асуулгад нэмж, энэ чиглэлээрх зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Түүнчлэн ҮОХДТ,

санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр газар дээрх зорилтот хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

## 8.2. Мэдээ мэдээллийг олж авч болох эх сурвалжууд

МУТСТ, ҮОХДТ чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэдээлэх үүрэгтэй этгээд, тэдгээрийн комплаенсын ажилтан, удирдлага болон ажилтнууд, иргэд дараах эх сурвалжуудаас мэдээ мэдээллийг авах боломжтой. Үүнд:

- СЗХ-ны цахим хуудасны “Мөнгө угаахтай тэмцэх” цэс: <http://www.frc.mn/frc/muta/d/gc/8464>
- МУТСТ тухай мэдээллийн нэгдсэн систем: <https://amlcft.mn/>
- СМА-гийн цахим хуудас: <https://fiu.mongolbank.mn/>
- ФАТФ-ын цахим хуудас: <https://www.fatf-gafi.org/>
- АНДМУТБ-ийн цахим хуудас: <http://www.apgml.org/>
- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээнд орсон этгээдийн жагсаалт: <https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот 15160,  
Бага тойруу 3, Засгийн Газрын IV байр.

**Утас:** (976)-51 261112, 261113

**Вэбсайт:** [www.frc.mn](http://www.frc.mn)